

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	5
1.2. Толгойт дэд төвийн танилцуулга	6
1.2.1. Байршил	6
1.2.2. Төслүүдийн товч танилцуулга, хэрэгжилтийн байдал	7
1.2.3. Төслийн ус болон цахилгаан хангамж	10
1.2.4. Төсөлд ашиглах түүхий эд, материал	10
2. ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ	11
2.1. Толгойт дэд төв орчмын агаарын чанар	11
2.1.1. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд.....	11
2.1.2. Агаарын массын хөдлөл зүй	12
2.1.3. Толгойт дэд төвийн талбайн орчмын агаарын чанарын төлөв байдал	13
2.2. Толгойт дэд төв орчмын усан орчин.....	18
2.3. Толгойт дэд төв орчмын хөрсөн бүрхэвчийн хими, физик шинж чанар	28
2.3.1. Толгойт дэд төв орчмын хөрсний бичил элементийн мониторингийн үр дүн.....	31
2.4. Толгойт дэд төвийн ургамлын нөмрөг	37
2.5. Толгойт дэд төв орчмын амьтдын тархалт	40
2.6. Төслийн талбайн нийгэм, эдийн засгийн товч тодорхойлолт	45
3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	48
3.1. Уур амьсгалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ.....	48
3.2. Цэвдэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	49
3.3. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	50
3.4. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	51
3.5. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	52
3.6. Ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	53
3.7. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл, хамрах хүрээ	53
3.8. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлж болзошгүй нөлөөлөл тодорхойлох.....	54
3.9. Болзошгүй сөрөг нөлөөллийн тархалтын түвшнийг тодорхойлох.....	55
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ..	57
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	60
5.1. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11 болон TRDH14):.....	60
5.2. Мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт (TEC).....	65
5.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP):.....	70
5.4. Салбар шугам холбох багц ажил (SHTSC)	74
5.5. Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн ажил (SHTL):	79
5.6. Эрүүл мэндийн төв барих ажил (PHC):	83
5.7. Сургалтын төв барих ажил (TBC):.....	87
5.8. Ерөнхий боловсролын сургууль барих ажил (TSC)	92
6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:	97
6.1. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11 болон TRDH14):.....	97
6.2. Мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт (TEC).....	99
6.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP):.....	101
6.4. Салбар шугам холбох багц ажил (SHTSC)	103
6.5. Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн ажил (SHTL):	105
6.6. Эрүүл мэндийн төв барих ажил (PHC):	106
6.7. Сургалтын төв барих ажил (TBC):.....	108
6.8. Ерөнхий боловсролын сургууль барих ажил (TSC)	110

7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	113
7.1. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11 болон TRDH14):.....	113
7.2. Мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт (TEC).....	114
7.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP):.....	114
7.4. Салбар шугам холбох багц ажил (SHTSC)	115
7.5. Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн ажил (SHTL):	116
7.6. Эрүүл мэндийн төв барих ажил (PHC):	117
7.7. Сургалтын төв барих ажил (TBC):.....	118
7.8. Ерөнхий боловсролын сургууль барих ажил (TSC)	119
8. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	120
9. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	121
9.1. Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	121
9.2. Нөхөн сэргээлтийн үе шат	122
9.3. Нөхөн сэргээлтийн нийт зардал.....	123
9.3.1. 2024 оны нөхөн сэргээлтийн зардлын хураангуй.....	123
9.3.2. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	123
10. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	124
11. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	124
12. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	125
13. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ).....	126
13.1. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11A,B,D болон TRDH14):.....	126
13.2. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11C):.....	127
13.3. Мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт (TEC).....	128
13.4. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP):.....	128
13.5. Салбар шугам холбох багц ажил (SHTSC)	129
13.6. Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн ажил (SHTL):	130
13.7. Эрүүл мэндийн төв барих ажил (PHC):	130
13.8. Сургалтын төв барих ажил (TBC):.....	131
13.9. Ерөнхий боловсролын сургууль барих ажил (TSC)	131
Хавсралт.....	132

Зургийн жагсаалт

Зураг 1. Дэд төв, төслийн талбайн байршил.....	6
Зураг 2. Толгойт дэд төв төслийн талбайн гадаргын морфометрийн зарим үзүүлэлт.....	11
Зураг 3. Толгойт дэд төв орчмын агаарын бохирдлын эх үүсвэр	11
Зураг 4. Агаарын массын шилжилт	12
Зураг 5. Хүхэрлэг хийн сарын явц, хоногийн дунджаар	13
Зураг 6. Хүхэрлэг хийн хоногийн явц, цагийн дунджаар	14
Зураг 7. Азотын давхар ислийн сарын явц, хоногийн дунджаар.....	15
Зураг 8. Азотын давхар ислийн хоногийн явц, цагийн дунджаар	15
Зураг 9. PM10 тоосонцрын агууламжийн сарын явц	16
Зураг 10. PM2.5 тоосонцрын агууламжийн сарын явц	17
Зураг 11. Нарангийн булгийн эхийн орчим.....	18
Зураг 12. Нарангийн булаг оршуулгын доор.....	19
Зураг 13. Нарангийн булгийн гэр хороолол дунд урсаж буй байдал	20
Зураг 14. 18-р цэгийн баруун талд, Шинэ сувгийн далан доторх тогтоол ус	20
Зураг 15. 19-р цэгийн ойролцоо урсгалгүй тогтоол ус	21
Зураг 16. Ш.Доржийн худаг	22
Зураг 17. “Экстид” ХХК-ны худаг	22
Зураг 18. Отгонбаярын худаг	23
Зураг 19. “ТЭСО” ХХК-ны худаг	23
Зураг 20. “Хүннү Конкрет” ХХК-ны худаг	24

Зураг 21. Никелийн аюулын тоо хэмжээний орон зай, цаг хугацааны ялгарал	25
Зураг 22. Хүнцилийн аюулын тоо хэмжээний орон зай, цаг хугацааны ялгарал	26
Зураг 23. Хүнцилийн аюулын тоо хэмжээний орон зай, цаг хугацааны ялгарал	26
Зураг 24. Хөрсний урвалын орчин	28
Зураг 25. Хөрсний ялзмагийн агууламж, %	29
Зураг 26. Хөрсний цахилгаан дамжуулах чанар	30
Зураг 27. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P ₂ O ₅)-ийн агууламж	31
Зураг 28. Хөрсөн дэх калийн исэл (K ₂ O)-ийг агууламж	31
Зураг 29. S-13-р цэгийн орчмын харагдах байдал	35
Зураг 30. S-15-р цэгийн баруун болон зүүн талын харагдах байдал	35
Зураг 31. S-18-р цэгийн орчмын харагдах байдал	35
Зураг 32. S-23 цэгийн орчмын харагдах байдал	36
Зураг 33. S-25 цэгийн дээд болон доод хэсэг болон ус урсаж байх үеийн харагдах байдал	36
Зураг 34. Хөрсний бохирдлын нийлбэр индекс	36
Зураг 35. Толгойт дэд төв орчмын хөрсний бохирдлын нийлбэр ачаалал	37
Зураг 36. Ургамлын үржлийн ба ургал шатны зүйлүүдийн эзлэх хувийн жин, %	38
Зураг 37. Ажиглалтын талбайн ургамлын зүйлийн тооны хэлбэлзэл, ширхэг	39
Зураг 38. Ургамлын үржлийн ба ургал шатны зүйлүүдийн эзлэх хувийн жин, %	39
Зураг 39. IV болон X сард ажиглаж бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүд	40
Зураг 40. IV сард мониторингийн цэгт бүртгэсэн хөхтөн, шувууны тоо	41
Зураг 41. X сард мониторингийн цэгт бүртгэсэн хөхтөн, шувууны тоо	41
Зураг 42. X сард мониторингийн цэгт бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүд ба тоо	42
Зураг 43. Бүртгэгдсэн хөхтөн, шувууны зүйлүүдийн тархалт (IV сар)	43
Зураг 44. Бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүдийн тархалт (IV сар)	43
Зураг 45. Бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүдийн тархалт (X сар)	44
Зураг 46. Бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүдийн тархалт (X сар)	44
Зураг 47. Бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүдийн тархалт (X сар)	45
Зураг 48. Төслийн талбайгаас гарсан агаарын массын тархалт (HYSPLIT загвар)	48

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн хүрээнд 2024 онд хэрэгжих дэд төслүүдийн мэдээлэл	7
Хүснэгт 2. ТДТ орчмын агаарын чанарын гол элементийн сарын дундаж	13
Хүснэгт 3. ТДТ орчмын агаар дахь хүхэрлэг хийн агууламжийн орон зайн өөрчлөлт, нөлөөлөл ..	14
Хүснэгт 4. ТДТ орчмын агаар дахь NO ₂ -ийн агууламжийн орон зайн өөрчлөлт, нөлөөлөл	16
Хүснэгт 5. ТДТ орчмын агаар дахь тоосонцрын агууламжийн орон зайн өөрчлөлт, нөлөөлөл ..	17
Хүснэгт 6. ТДТ орчмын дуу шуугианы орон зайн өөрчлөлт, нөлөөлөл	18
Хүснэгт 7. Нарангийн булгийн усны химийн шинжилгээний дүн, мг/л	19
Хүснэгт 8. Сувгийн усны химийн шинжилгээний дүн, мг/л	20
Хүснэгт 9. Газрын доорх усны химийн шинжилгээний дүн, мг/л	21
Хүснэгт 10. Үл хүлцэх эрсдэлийн түвшин, химийн элементээр	24
Хүснэгт 11. Нарангийн булгийн усны бичил амь судлалын үзүүлэлт	27
Хүснэгт 12. Худгуудын усны бичил амь судлалын үзүүлэлт	27
Хүснэгт 13. Толгойт орчмын хөрсний онцгой хортой, био-идэвхт хүнд металлын агууламж	32
Хүснэгт 14. Мониторингийн цэг дэх шувуу, хөхтний элбэгшил	42
Хүснэгт 15. Толгойт дэд төвийн газар нутагт хамрагдах хүн амын тоо	45
Хүснэгт 16. Уур амьсгалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	48
Хүснэгт 17. Цэвдэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	49
Хүснэгт 18. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	50
Хүснэгт 19. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	51
Хүснэгт 20. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	52
Хүснэгт 21. Ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	53
Хүснэгт 22. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн хамрах хүрээ	53
Хүснэгт 23. Нөлөөллийн үзүүлэлт ба оноо	54
Хүснэгт 24. Нөлөөллийн зэргийн шалгуур	55
Хүснэгт 25. Нөлөөллийг үнэлэх шалгуур	55
Хүснэгт 26. Төслийн байгаль орчныг хянах хүснэгт	56
Хүснэгт 27. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	59
Хүснэгт 28. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TRDH11 болон TRDH14 багцууд)	60
Хүснэгт 29. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TEC)	65
Хүснэгт 30. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TFP багц)	70
Хүснэгт 31. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (Салбар шугам багц)	75

Хүснэгт 32. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (SHTL багц)	79
Хүснэгт 33. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (PHC багц)	83
Хүснэгт 34. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TBC багц)	87
Хүснэгт 35. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TSC багц)	92
Хүснэгт 36. Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	121
Хүснэгт 37. Нөхөн сэргээлтийн зардлын нэгдсэн дүн багц бүрээр /2024 онд/	123
Хүснэгт 38. Газар эзэмшлийн нөхцөл байдал	124
Хүснэгт 39. “Толгойт” дэд төв нөхөн олговор	124

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичгийн дагуу хотын гэр хорооллын дэд бүтэц, нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулах, тогтвортой хөгжүүлэхэд чиглэгдсэн арван жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын хөтөлбөр бөгөөд төсөл хэрэгжсэнээр агаар, хөрс, усны бохирдол буурч, тухайн нутаг дэвсгэр дэх оршин суугчдын эрүүл аюулгүй амьдрах эрх хангагдана гэж үзэж байна.

Энэхүү хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүн, нөлөөлөл нь Улаанбаатар хотын амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах явдал юм. Энэхүү хөтөлбөрийн гол зорьж буй үр дүн нь УБ хотын гэр хорооллыг тогтвортой, олон талыг хамардаг, сайн-бүтэцтэй болгон хөгжүүлэх явдал юм. Хөтөлбөрөөс гарах үр дүн нь: (i) эдийн засгийн боломжууд, байшин барилга барих, хөдөлмөр эрхлэх боломж олгох, байгаль орчинд үүсэх нөлөө, тухайлбал: хөрс, агаарын бохирдолтой холбогдох нөлөөг багасган дэд төвүүдийг хөгжил сайтай бүс болгох; (ii) ус хангамж, бохир ус, дүүргийн халаалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг санхүүгийн хувьд бие даасан өндөр чанартай үйлчилгээ үзүүлдэг болгох зорилгоор орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах боломжтой болгох; (iii) зах зээлийн таатай орчин, зохистой хууль эрх зүйн орчинд үндэслэсэн оновчтой, олон нийтээр идэвхтэй оролцдог өсөлтөд чиглэсэн хот төлөвлөлтийн тогтолцоог бий болгох зэрэг юм.

Толгойт дэд төв төслийн хүрээнд нийт 30 ажил хамаарч байгаагаас 2023 оны 12-р сарын байдлаар 21 багц ажил хэрэгжиж эхлээгүй, 4 ажил дууссан, 2024 онд 26 ажлын бүтээн байгуулалт хийгдэхээр төлөвлөж байна.

Толгойт дэд төвийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) 2023 оны 5-р сард БОАЖЯ-аар батлагдсан. Тус БОННУ-ний хамтаар 2023-2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) батлагдсан. 2023-2026 оны БОМТ болон төслүүдийн 2024 оны үйл ажиллагаатай уялдуулан 2024 оны БОМТ-г “Байгаль орчин, ногоон хөгжлийн яам”-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 дугаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: Толгойт дэд төв

Төслийн дугаар: 13/3270

Төслийн зорилго:

Гэр хороололд орон сууц, хүүхдийн цэцэрлэг, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг бий болгоход төслийн зорилго оршино.

Төсөл хэрэгжүүлэгч:

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж”

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Бага тойрог-1, Амарын гудамж-2, Соёлын төв өргөө Г корпус/415 тоот.

Холбоо барих утас: 9103-3373, 9976-7000-3099,

Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:

Төслийн зохицуулагч: Д.Авирмэд


Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:

З.Мөнх-Оргил, 70003099, munkh-orgil@ub-subcenter.mn

1.2. Толгойт дэд төвийн танилцуулга

1.2.1. Байршил

Толгойт дэд төв нь нийт 551,4 га газар нутгийг хамрах бөгөөд засаг захиргааны хувьд Сонгинохайрхан дүүргийн 1, 2,3, 20, 35 дугаар хороод багтдаг.



Зураг 1. Дэд төв, төслийн талбайн байршил

1.2.2. Төслүүдийн товч танилцуулга, хэрэгжилтийн байдал

Толгойт дэд төв төслийн хүрээнд нийт 29 ажил хамаарч байгаагаас 2023 оны 12-р сарын байдлаар 21 багц ажил хэрэгжиж эхлээгүй, 4 ажил дууссан, 2024 онд 26 ажлын бүтээн байгуулалт хийгдэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 1. Төслийн хүрээнд 2024 онд хэрэгжих дэд төслүүдийн мэдээлэл

№	Багцын дугаар	Багцын нэр	Хийгдэх ажил
1	ТЭС	А	ТДТ-ийн мэдээлэл холбооны шугам сүлжээ
2		В	ТДТ-ийн цахилгааны хаалттай дэд өртөө ба 10кВ цахилгаан дамжуулах кабель шугам
3		С	ТДТ-ийн цахилгааны хуваарилах байгууламжууд ба 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам
4	TRDH11	А	ТДТ-д хийгдэх ариутгах татуургын шугам суурилуулалтын ажил
5		В	ТДТ-ийн авто замын ажил
6		С	ТДТ-ийн насосын станц болон усан шугам сүлжээ
7		Д	ТДТ-ийн авто зам
8	TRDH14	А	ТДТ-ийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (1-р хэсэг)
9		В	ТДТ-ийн авто зам, дулааны сүлжээ

			болон бусад дагалдах ИШС (2-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> - Ф100мм-Ф500мм хүртэл голчтой 1.14 км Гадна ариутгах татуургын угсралтын ажил - 2.15км урт Ф32мм-Ф350мм хүртэл голчтой Гадна дулааны шугам сүлжээний ажил; - 2.63км урт Ф50мм-Ф300мм хүртэл голчтой Гадна цэвэр усны шугам угсралтын ажил; - Ус дулаан дамжуулах төв №1 ба №5-ын барилга угсралтын ажил; - Кабель шугам, эрчим хүчний байгууламжийг хүчитгэх, шилжүүлэх, буулгах ба шинээр татах ажлууд 	
10		A	ТДТ-ийн тохижилт, ногоон байгууламжийн ажил (байршил 1)	<ul style="list-style-type: none"> - Багц 1: ТДТ дэх ногоон байгууламж бүхий тохижилттой талбай 4197.92м2 явган зам, дугуйн зогсоол, явган гүүр, тоглоомын талбай, амрах хэсэг, ногоон байгууламж, талбайн гэрэлтүүлэг, камержуулалтын ажлаас бүрдэнэ. - Багц 2: ТДТ дэх ногоон байгууламж бүхий тохижилттой талбай 2433.64м2 явган зам 497.13м2, дугуйг зам 154.09м2, тоглоомын талбай 240.83м2, авто зогсоол 149.2м2, ногоон байгууламж 358м2 	
11		B	ТДТ-ийн тохижилт, ногоон байгууламжийн ажил (байршил 2)	<ul style="list-style-type: none"> - Нийт - 1.45га - 4,119.37м2 - Авто зам болон машины зогсоол - 7,233.36м2 - Ногоон байгууламж - Сагсан бөмбөгийн талбай (2 шиттэй) 3х3 сагсан бөмбөгийн талбай, Гар бөмбөгийн талбай, Агаарын теннисний талбай, Хүүхдийн тоглоомын талбай, Ахмад насан болон өсвөр насны хүүхдүүд хичээллэх зориулалттай чийрэгжүүлэх талбай, Дугуйн зам, Гүйлтийн зам, Тамхины цэг, Био жорлон - Тохижилтын хэмжээнд 45ш автомашины зогсоол /Авто зам дагуух 30ш, тусдаа 17ш зогсоолоос автобусны зогсоол 1ш, ХБИ-ий зогсоол 2ш/ - Дугуйн зогсоол /6ш дугуй зогсох/, Саад саравч бүхий талбай, Нийтийн цуглах талбай, Явган зам талбай /ХБИ-ий хөтөгч хавтан бүхий/, Сэндвич харуулын байр 	
12	SHTL	C	1	СХД-ийн 8-р хорооны 50 айлын орон сууцны барилгын урд талбайн бичил тохижилт болон СХД-ийн 9 дүгээр хороонд 3х3 сагсан бөмбөгийн талбайн тохижилт	<ul style="list-style-type: none"> - 50-айлын урд талбайн тохижилт: Уг талбайд явган хүний зам 246 м2, саравч 1 ширхэг, тоглоомын талбай /6 сар-4 нас/ 87 м2, усан оргилуур 1ш, ногоон байгууламж 398 м2 байхаар тус тус төлөвлөв. Ногоон байгууламж 398кв.м буюу нийт тохижилтын талбайн 54.2% эзлэхээр төлөвлөв. - Сагсны талбай: Уг талбай нь “3х3” төрлийн спортын талбай бөгөөд үндсэн тоглолтын талбай нь 13.9х17.9м хэмжээтэй байна. Хашаан дотроо 1.5м өргөнтэй явган хүний зам, 2 ширхэг сандал, 1ширхэг хогны сав байна. Хашааны өндөр 3.5м төмөр сараалжин. Төв замаас сагсны талбай руу холбогдох явган замтай.
13			2	СХД-ийн 10-р хороонд бичил тохижилтын ажил	<ul style="list-style-type: none"> - Уг талбай нь хүүхэд залуучуудад зориулсан жижиг хэмжээний экстрим талбайтай, хаданд авиралтын ханатай, 2 саравч, 3 сандал, 1 хогны сав, 1.5м өргөнтэй явган зам, явган зам дагуух ногоон байгууламж хэсэгтэй. Нийт талбайн 47.31% буюу 231.32м2ногоон байгууламж, 9.98% буюу 43.93м2 явган зам, 40.68% буюу 194.02м2 экстрем талбай, 2.18% буюу 10.69м2 хаданд авиралтын хана байна.
14			3	СХД-ийн 8-р хороо, нийслэлийн 261 дүгээр цэцэрлэгийн гадна нэмэлт авто зогсоолын ажил”	<ul style="list-style-type: none"> - 261-р цэцэрлэгийн хажуугийн авто зам дагуух газар 21 машины зогсоол төлөвлөсөн. 2 зогсоол нь тэргэнцэртэй иргэний авто машины зогсоол байна. Нийт талбайн 50.95% буюу 981.13м2 авто зогсоол, 48.56% буюу 935.26м2 ногоон байгууламж, 0.49% буюу 73.81м2 явган зам талбай байна. Авто зогсоол нь байгалийн шигтгэмэл чулуу байна.
15			4	СХД-ийн 8-р хороо, бизнес инкубатор төвийн гадна нэмэлт авто зогсоолын ажил	<ul style="list-style-type: none"> - Бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төвийн хажууд 13 машины зогсоол төлөвлөсөн. 1 зогсоол нь тэргэнцэртэй иргэний авто машины зогсоол байна. Авто зогсоол нь байгалийн шигтгэмэл чулуу байна.
16			5	СХД-ийн 8-р хороо, Баянхошуу бизнес	<ul style="list-style-type: none"> - Бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төвийн хажууд 13 машины зогсоол төлөвлөсөн. 1 зогсоол нь

			инкубатор төв болон нийслэлийн 261 дүгээр цэцэрлэгийн барилгын гадна фасадны засварын ажил	тэргэнцэртэй иргэний авто машины зогсоол байна. Авто зогсоол нь байгалийн шигтгэмэл чулуу байна.
17		D	Сэлбэ дэд төв дэх нийтийн зориулалттай ногоон байгууламж ба гадна талбайн тохижилтын ажлууд	<ul style="list-style-type: none"> - Багц 1- Сүхбаатар дүүргийн 14-р хороо, 35-р сургуулийн арын тохижилт: Нийт 1266м² талбайтай, явган зам 390.72м², спорт талбай 420м², дасгалын талбай 152.27м², саравч 3ш, 6-4 насны тоглоомын талбай 147.73м², 5-12 насны хүүхдийн тоглоомын талбай 152.27м², ногоон байгууламжийн талбай 625.15м² - Багц 2 - Сүхбаатар дүүргийн 14-р хороо, 50 айлын баруун талд 3х3 сагсан бөмбөгийн талбай: Нийт талбай 800м² байгууламж ба гадна талбайн тохижилтын ажил - 50 айлын орон сууцын зүүн хойд талд 0.025 га талбайд “3х3” төрлийн сагсан бөмбөгийн талбайн ажил
18	SC	A	Дэд төвийн байршлын талбайн цэвэрлэгээний ажил (1-р шат ,2-р шат)	<ul style="list-style-type: none"> - 160 нэгж талбар Баянхошуу, Дамба, Толгойт - Дууссан
19		B		
20	TFP	TFP	ТДТ-ийн үерийн усны хамгаалалтын суваг (1-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> - ТДТ-ийн үерийн хамгаалалт, ус зайлуулах - Үерийн усны хамгаалалтын суваг - Тунгаах байгууламж 2ш - Далд хоолой 2 байрлалд - Одоо байгаа далд хоолойг өргөсгөх 1 байрлалд - Автомашин болон явган хүний гарц 2 байрлалд - Дууссан
21		A	ТДТ-ийн үерийн усны хамгаалалтын суваг (2-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> - ТДТ-д (Баруун наран) үерийн хамгаалалт, ус зайлуулах хоолой - Үерийн усны хамгаалалтын суваг - Автомашин болон явган хүний гарц 5 байрлалд далд хоолой
22	SHTSC	A	Толгойтын ус, бохир ус, дулааны хоёрдогч холболт (Цэргийн хотхон)	<ul style="list-style-type: none"> - Ф530х8мм-ийн голчтой 1.3 км дулааны шугамын угсралтын ажил
23		B	Баянхошуу дэд төв(Оргил)-ийн цэвэр, бохир ус, халуун ус, дулаан түгээх шугам сүлжээний нийлүүлэлт, суурилуулалт	<ul style="list-style-type: none"> - Ариутгах татуургын шугам - 3км Гадна цэвэр усны шугам - 1,6км Дулаан хангамжийн шугам - 2км УДДТ-2ш
24		C	Дэд төвүүдийн бохир ус, дулааны хоёрдогч холболт	<ul style="list-style-type: none"> - Ариутгах татуургын шугам – 1.5км - Дулаан хангамжийн шугам – 1 км
25		SHTSC	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил	<ul style="list-style-type: none"> - Хийн халаалтын зуух суурилуулах ажил -9ш сургуульд нөөц цахилгаан үүсгэвэр суурилуулах ажил – 4 сургууль Ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажил – 5ш сургууль Бохир усны саармагжуулах төхөөрөмж суурилуулах ажил – 1ш сургууль - Дууссан
26	TFS		106-р сургуулийн хөл бөмбөгийн талбай.	<ul style="list-style-type: none"> - 7608м² талбайд хийгдэнэ.
27	TBC		ТДТ сургалтын төв	<ul style="list-style-type: none"> - Тэнхлэгээрээ 50.0 х 33.0 м хэмжээтэй, хагас нум хэлбэртэй болон тэгш өнцөгтийн блокоос бүрдсэн 2 давхар, 2081 м² талбай

28	PHC	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төв	<ul style="list-style-type: none"> - СХД-ийн 34-р хороонд байрлах 15 ортой эмнэлэг - Барилгын нийт талбай - 4103.11м² - Зоорийн давхартай, 3 давхар барилга - 25 ил автомашины зогсоол - Ногоон байгууламж-1627.2м²
29	TSC	ТДТ-ийн бага сургууль. 320суудалтай, Ерөнхий боловсролын дунд сургууль	<ul style="list-style-type: none"> - Буулгалтын ажил 1958 онд ашиглалтад орсон дан давхар 386.5м² хичээлийн байр буулгах. - Гадна тохижилтын ажил нийт 5820м² талбайд автозам, явган зам талбай, эргийн бэхэлгээ, дугуйн зам, дугуйн зогсоол, сүүдрэвч, гэрэлтүүлэг, бялдаржуулах талбай, тавцант гулгуурын талбай, авто зогсоол, ногоон байгууламжаас бүрдэнэ. - Зоорийн давхартай, 3 давхар 640 хүүхдийн сургуулийн барилга. Нийт талбай 4704.6м² гадна инженерийн шугам сүлжээний хамт

1.2.3. Төслийн ус болон цахилгаан хангамж


Толгойт дэд төвийн барилгын ажил болох 28 багц ажлын хүрээнд 20-25 компани барилгын ажил гүйцэтгэхээр байна. Тухайн газар ажиллах хүн хүчний хувьд нэг компани /Аж ахуйн байгууллага/ 20-30 хүнтэй гэж тооцвол нийт 400-750 хүн ажиллах болно. Барилгын ажлын хүрээнд ашиглах усыг төвлөрсөн шугам болон УСУГ-ын харьяа гүний худгуудаас авч хэрэглэнэ. Толгойт дэд төвийн цэвэр усан хангамж нь дараах эх үүсвэртэй бөгөөд 3–р үе шатны хүрээнд СХД-ийн 1,2, 3 болон 34,35 дугаар хороонд Төвлөрсөн шугамд холбогдсон 12 ширхэг худаг, Ахуйн хэрэглээний 44 худаг байна.

1.2.4. Төсөлд ашиглах түүхий эд, материал

Толгойт дэд төв төслийн бүс орчимд байрлах тусгай зөвшөөрөл бүхий түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газруудаас түүхий эд, материал татахаар төлөвлөж байна.

2. ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

Толгойт дэд төвийн газар нутаг нь физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужийн Хэнтийн захын уулсын тойрогт хамаарна. Тус газар нутаг нь 1252-1398 м өндөрт өргөгдсөн, уулын хөндий хотос газраар 0-6° бөгөөд хот суурин газар төлөвлөхөд геоморфологийн төвөгшил бага юм.




Зураг 2. Толгойт дэд төв төслийн талбайн гадаргын морфометрийн зарим үзүүлэлт

Уур амьсгалын мужлалаар хуурайдуу сэрүүн зунтай, хахирдуу өвөлтэй бүсэд оршино.

2.1. Толгойт дэд төв орчмын агаарын чанар

2.1.1. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд

Агаарын бохирдлын эх үүсвэрийг талбайн, шугаман, цэгэн эх үүсвэр гэж 3 ангилан авч үзлээ (Зураг 3). Төслийн талбайд тархах агаар бохирдуулагч эх үүсвэрийг дээрх 3 ангиллаар ангилав. Төслийн талбайд орших уурын зуухнууд нь цэгэн эх үүсвэр юм. Уурын зуухны хүчин чадал, байршил зэрэг мэдээллийг хавсаргав (Хавсралт-1).




Зураг 3. Толгойт дэд төв орчмын агаарын бохирдлын эх үүсвэр

Гэр хорооллын айл өрхүүдийн яндангаас ялгарах хийн хаягдлыг эх үүсвэрийг талбайн эх үүсвэр болгон авч нэгж талбайн эх үүсвэрийн хаягдлын хэмжээг тодорхойлохдоо тухайн талбайд багтах гэр хорооллын тоог нэг гэрээс ялгарах хаягдлын хэмжээгээр үржүүлэн эзлэх талбайд нь хувааж олдог байна. Түүнийг нэгж хугацаанд, нэгж талбайгаас ялгарах массаар илэрхийлэх бөгөөд талбайн эх үүсвэрийн геометр хэмжээнээс хамаарч харилцан адилгүй байна. Төслийн талбайд хамаарах гэр хорооллын айл өрхүүдийг 9 талбайн эх үүсвэрт хуваасан болно.

Шугаман эх үүсвэрт шороон зам орно. Шороон замыг төслийн талбайн хүрээнд Google Earth платформын мэдээг ArcGIS программд оруулж дижитайз хийж зураглав. Төслийн талбайн хүрээнд шороон замын нийт урд 69043.78 м буюу 70 орчим км байна.

2.1.2. Агаарын массын хөдлөл зүй

Дүүргийн хойноос баруун урагш чиглэсэн Рашаантын урт хөндийд -20 хэмээс хүйтэн өргөн зурвас байх бөгөөд уг хөндийн хойд хэсэг Нарийны, Хутагт Өндөр, Багаагийн амын бэлчир өргөн хөндийд -24 - -21.5^oС, дунд хэсэгт -22 – -21.5^oС, урд хэсэгт -23.5 - -21.5^oС-ийн хүйтний голомт байна. Сонгино хайрхан уулаас зүүн тийших хөндийд -22.5 - -22^oС-ийн хүйтэн голомт байна. Баруун хойд хэсэгт орших Согоот, Цагаан чулуут уул, түүнээс урагш орших Хөндлөн уул, Хар модтын даваа, дүүргийн зүүн дунд хэсэгт орших Улаан дэл, Толгойтын уул тус тус -17.5 - -17^oС-ийн голомт, -19.5 - -18^oС-ийн зурвас үүсгэж байна. Толгойт, Баянхошууны гэр хороолол -21.5 - -21^oС-д, Толгойтын баруун, зүүн салааных -20.5 - -19^oС-д байна.



Зураг 4. Агаарын массын шилжилт

2.1.3. Толгойт дэд төвийн талбайн орчмын агаарын чанарын төлөв байдал


Агаар дахь хүхэрлэг хийн агууламжийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлт

Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 3-р хороо, 65-р сургууль орчмын агаарын чанарын харуулын 2023 оны 1-10-р сарын хүхэрлэг хий, азотын давхар исэл, PM₁₀, PM_{2.5} тоосонцор гол бохирдуулах бодисуудын минутын давтамжтай дүнгээр Толгойт орчмын агаарын чанарын төлөв байдлыг тодорхойлж хөндлөнгийн хяналтын хүрээнд хийсэн хэмжилттэй харьцуулав. NO_x

Хүснэгт 2. ТДТ орчмын агаарын чанарын гол элементийн сарын дундаж

Сар	NO _x , ug/m ³	PM ₁₀ , ug/m ³	PM _{2.5} , ug/m ³	SO ₂ , ug/m ³
1	19.37	77.79	75.07	368.25
2	135.14	47.82	45.49	239.70
3	85.53	33.38	26.58	120.51
4	41.23	17.68	12.22	66.31
5	26.77	4.31	3.00	31.61
6	20.14	0.78	0.61	12.14
7	19.72	0.39	0.39	12.63
8	25.12	4.02	2.52	10.77
9	108.57	24.00	10.00	3.25
дундаж	30.61	17.49	15.64	83.17

Хүхэрлэг хий нь ихэвчлэн нүүрс, мазут зэрэг хүхэр агуулсан түлшийг шатаахад ялгарна. Толгойт орчмын агаар дахь хүхэрлэг хийн агууламжийг MNS4585:2016 стандарттай харьцуулбал 2023 оны 1-р сард 7.4 дахин их, 2-р сард 4.8 дахин их, 3-р сард 2.4 дахин их, 4-р сард 1.3 дахин их, 5-р сараас хойш багассан байна. Энэ нь нэг талаар галлагаа эхэлснээр агаарт гаргах бохирдуулах бодисын хэмжээ нэмэгддэг, нөгөө талаар температурын инверс, салхигүй хүйтэн өвөл зэрэг цаг агаарын тааламжгүй нөхцөл бүрэлддэгтэй холбоотой. Үүнийг агаар дахь хүхэрлэг хийн агууламжийн хоногийн явцаас тодорхой харж болно.



Зураг 5. Хүхэрлэг хийн сарын явц, хоногийн дунджаар

Хүхэрлэг хийн хоногийн явцаас үзэхэд шөнө 1 цаг хамгийн их агууламж буюу 117.1 мкг/м³ хүрээд шөнийн 6 цаг хүртэл 89 мкг/м³ болж буураад гэр хорооллын айл өрхүүдийн галлагаа эхлэхтэй зэрэгцээд 9 цаг хүртэл нэмэгдээд 102.32 мкг/м³ болж байна. Үүнээс цааш 17 цаг хүртэл буурч 33.42 мкг/м³ хүрээд мөн галлагаатай холбоотой 6 цагаас хойш буцаад нэмэгдэж байна.



Зураг 6. Хүхэрлэг хийн хоногийн явц, цагийн дунджаар


Толгойт дэд төвийн орчим хүхэрлэг хийн орон зайн тархалт буюу хэмжилт хийсэн цэгүүдийн хүрэн дэх өөрчлөлт, нөлөөллийг тодорхойлох зорилгоор гүйцэтгэсэн. Тус хэмжилтээр хүхэрлэг хийн агууламж 2022-2023 оны хэмжилтээр 0.011-0.018 мкг/м³ буюу MNS 4585:2016 стандартад заасан хэмжээнээс бага байв. Хэмжилт хийсэн хугацаанд хүхэрлэг хийн агууламж 0.007 мкг/м³ зөрүүтэй буюу хэмжилт хийсэн цэгүүдэд жигд тархалттай байна. Энэ нь галлагаагүй байсантай холбоотой юм. Толгойт дэд төвийн төслүүд хэрэгжиж буй цэгүүдэд мөн 0.007 мкг/м³ далайцын хүрээнд байгаа нь эдгээр төслүүдийн зүгээс орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламжийг өөрчлөх хэмжээний нөлөөлөл үзүүлээгүйг илтгэнэ.

Хүснэгт 3. ТДТ орчмын агаар дахь хүхэрлэг хийн агууламжийн орон зайн өөрчлөлт, нөлөөлөл

Байршил	SO ₂ , мг/м ³		
	2022 он 7-р сар	2023 он 5-р сар	2023 он 6-р сар
СХД, 20-р хороо, ТЭСО ХХК-ийн агуулах	0.015		
СХД, 9-р хороо, Буман-Өлзий хорооллын баруун хойно	0.018		0.013
СХД, 22-р хороо, Иргэн Д.Батнасангийн дэлгүүрийн орчим, хатуу хучилттай зам дагуу	0.014		0.016
СХД, 1-р хороо, Гүнгэрваа худалдааны төвийн хашаан дотор	0.012	0.014	0.011
"Мандалт констракшн" ХХК, Бизнес инкубатор, сургалтын төв		0.018	
Далан-1		0.014	
Далан-2		0.016	
Үндэсний агаарын чанарын стандарт-MNS 4585:2016		0.45	


Агаар дахь азотын давхар ислийн агууламжийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлт

Азотын ислүүд нь харьцангуй өндөр температурт шаталт явагддаг автомашин болон цахилгаан станц, үйлдвэрлэлийн процессын хаягдал утаанаас ялгарна.



Зураг 7. Азотын давхар ислийн сарын явц, хоногийн дунджаар

Толгойт орчим азотын давхар исэл 2 болон 9-р саруудад 1.2-1.7 дахин их, бусад саруудад MNS4585:2016 стандартаас бага байна. Тус элементийн хоногийн явцаас үзэхэд 1-7 цаг хүртэл 20-35 мкг/м³, 7-12 цаг хүртэл 10-20 мкг/м³, 12-18 цаг хүртэл хамгийн бага утгатай, 18-23 цаг хүртэл 20-38 мкг/м³ болж байна. Азотын агууламжийн цагийн явцаас үзэхэд гэр хорооллын айл өрхүүдийн галлагааны горимтой хамааралтай байгаа нь анхаарал татаж байна.



Зураг 8. Азотын давхар ислийн хоногийн явц, цагийн дунджаар

Толгойт дэд төвийн орчим азотын давхар ислийн орон зайн тархалт буюу хэмжилт хийсэн цэгүүдийн хүрэн дэх өөрчлөлт, нөлөөллийг тодорхойлох зорилгоор гүйцэтгэсэн. Тус хэмжилтээр азотын давхар ислийн агууламж 2022-2023 оны хэмжилтээр 0.015-0.042 мкг/м³ буюу MNS 4585:2016 стандартад заасан хэмжээнээс бага байв. Хэмжилт хийсэн хугацаанд азотын давхар ислийн агууламж 0.023 мкг/м³ зөрүүтэй буюу хэмжилт хийсэн цэгүүдэд орон зайн өөрчлөлтэй болохыг харуулна. Энэ нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой болох нь харагдаж байна. Тухайлбал авто машины хөдөлгөөний эрчим хамгийн их Д.Батнасангийн дэлгүүр буюу ногооны худалдааны мухлаг орчимд 0.026 мкг/м³, Гүнгэрваа худалдааны төвийн орчимд 0.042 мкг/м³ байжээ.


Толгойт дэд төвийн төслүүд хэрэгжиж буй цэгүүдэд азотын давхар ислийн агууламж хэмжилтийн бүх утгын дундаж 0.025 мкг/м³ болон зөвшөөрөгдөх хэмжээнээс бага боловч жигд тархалттай буюу 0.021-0.022 мкг/м³ байна. Энэ нь хэмжилтийн үед төслийн барилгын ажил явагдаж, машин техникийн хөдөлгөөнтэй байсантай холбоотой юм.

Хүснэгт 4. ТДТ орчмын агаар дахь NO₂-ийн агууламжийн орон зайн өөрчлөлт, нөлөөлөл


Байршил	NO ₂ , мкг/м ³		
	2022 он 7-р сар	2023 он 5-р сар	2023 он 6-р сар
СХД, 20-р хороо, ТЭСО ХХК-ийн агуулах	0.038		
СХД, 9-р хороо, Буман-Өлзий хорооллын баруун хойно	0.025		0.022
СХД, 22-р хороо, Иргэн Д.Батнасангийн дэлгүүрийн орчим, хатуу хучилттай зам дагуу	0.033		0.026
СХД, 1-р хороо, Гүнгэрваа худалдааны төвийн хашаан дотор	0.042	0.019	0.015
"Мандалт констракшн" ХХК, Бизнес инкубатор, сургалтын төв		0.022	
Далан-1		0.022	
Далан-2		0.021	
Үндэсний агаарын чанарын стандарт-MNS 4585:2016	0.2		

Агаар дахь тоосонцрын агууламжийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлт

Агаар дахь тоосны агууламжийн сарын өөрчлөлтийг дараах зургаас харахад 1-р сард хамгийн их, 6, 7-р сард хамгийн бага агууламжтай байна. Агаарын харьцангуй чийг хамгийн их хаврын саруудад тоосонцрын агууламж хамгийн их агууламжтай байдаг байсан бол Толгойт орчим 1, 2-р сард хамгийн их байна.



Зураг 9. PM10 тоосонцрын агууламжийн сарын явц



Зураг 10. PM2.5 тоосонцрын агууламжийн сарын явц

Толгойт дэд төвийн орчим тоосонцрын орон зайн тархалт буюу хэмжилт хийсэн цэгүүдийн хүрээн дэх өөрчлөлт, нөлөөллийг тодорхойлох зорилгоор гүйцэтгэсэн. Тус хэмжилтээр тоосонцрын агууламж 2022-2023 оны хэмжилтээр 0.018-0.214 мкг/м³ буюу MNS 4585:2016 стандартад заасан хэмжээнээс бага байв. Хэмжилт хийсэн хугацаанд тоосонцрын агууламж 0.196 мкг/м³ зөрүүтэй буюу хэмжилт хийсэн цэгүүдэд орон зайн өөрчлөлтэй болохыг харуулна. Толгойт дэд төвийн төслүүд хэрэгжиж буй цэгүүдэд тоосонцрын агууламж хэмжилтийн бүх утгын дундаж 0.084 мкг/м³-ээс их, нийт хэмжилтийн өгөгдлийн хамгийн их утга буюу 0.214 мкг/м³ далангийн орчим ажиглагдсан. Энэ нь хэмжилтийн үед төслийн барилгын ажил явагдаж, машин техникийн хөдөлгөөнтэй холбоотой юм.

Хүснэгт 5. ТДТ орчмын агаар дахь тоосонцрын агууламжийн орон зайн өөрчлөлт, нөлөөлөл

Байршил	TSP, мкг/м ³		
	2022 он 7-р сар	2023 он 5-р сар	2023 он 6-р сар
СХД, 20-р хороо, ТЭСО ХХК-ийн агуулах	0.018		
СХД, 9-р хороо, Буман-Өлзий хорооллын баруун хойно	0.024		0.062
СХД, 22-р хороо, Иргэн Д.Батнасангийн дэлгүүрийн орчим, хатуу хучилттай зам дагуу	0.074		0.12
СХД, 1-р хороо, Гүнгэрваа худалдааны төвийн хашаан дотор	0.029	0.078	0.052
"Мандалт констракшн" ХХК, Бизнес инкубатор, сургалтын төв		0.084	
Далан-1		0.17	
Далан-2		0.214	
Үндэсний агаарын чанарын стандарт- MNS 4585:2016	0.5		

Дуу чимээний цаг хугацаа, орон зайн өөрчлөлт

Толгойт дэд төвийн орчим дуу шуугианы орон зайн тархалт буюу хэмжилт хийсэн цэгүүдийн хүрээн дэх өөрчлөлт, нөлөөллийг тодорхойлох зорилгоор гүйцэтгэсэн. Тус хэмжилтээр дуу шуугианы түвшин 2022-2023 оны хэмжилтээр 44-56 дБа буюу MNS 4585:2016 стандартад заасан хэмжээнээс бага байв. Хэмжилт хийсэн хугацаанд дуу шуугианы түвшин 12 дБа зөрүүтэй буюу хэмжилт хийсэн цэгүүдэд орон зайн өөрчлөлтэй болохыг харуулна. Хөл хөдөлгөөн ихтэй байдаг Гүнгэрваа худалдааны төв, Батнасангийн дэлгүүр орчимд дуу

чимээний түвшин 50-52 дБа байна. Харин толгойт дэд төвийн барилга, байгууламжийн ажил явагдаж буй цэгүүдийн орчим 52-56 дБа байна. Энэ нь нийт цэгүүдтэй харьцуулахад их боловч MNS 4585:2016 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна. Дэд төвийн төсөл хэрэгжиж буй цэгийн орчим бусад цэгүүдтэй харьцангуй их байгаа нь төсөлд ашиглаж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой юм.

Хүснэгт 6. ТДТ орчмын дуу шуугианы орон зайн өөрчлөлт, нөлөөлөл

Байршил	Дуу чимээ, дБа		
	2022 он 7-р сар	2023 он 5-р сар	2023 он 6-р сар
СХД, 20-р хороо, ТЭСО ХХК-ийн агуулах	50		
СХД, 9-р хороо, Буман-Өлзий хорооллын баруун хойно	48		50
СХД, 22-р хороо, Иргэн Д.Батнасангийн дэлгүүрийн орчим, хатуу хучилттай зам дагуу	50		50
СХД, 1-р хороо, Гүнгэрваа худалдааны төвийн хашаан дотор	52	50	44
"Мандалт констракшн" ХХК, Бизнес инкубатор, сургалтын төв		56	
Далан-1		52	
Далан-2		54	
Үндэсний агаарын чанарын стандарт-MNS 4585:2016			

2.2. ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ОРЧМЫН УСАН ОРЧИН

Нарангийн булгийн усны чанар

Булгийн усны температур 10.0-15.0°C-ын хооронд хэлбэлзэж, 2022 оны 7-р сарын дүнтэй харьцуулахад нэмэгдсэн байгаа бол усны орчин сул шүлтлэг рН 7.34-7.66 буюу 2022 оны 7-р сартай ойролцоо байна.

Нарангийн булгийн эх: Тус булгийн эх буюу ундардаг хэсгээс нь сорьц авч хэмжилт хийхэд химийн найрлагын хувьд гидрокарбонатын ангийн, кальцийн булгийн, 1-р төрлийн, цэнгэг, зөөлөвтөр устай байна (Хүснэгт 7).

Булгийн ус физик, хими болон бичил элементүүдээрээ 2022 оны 7-р сард "Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998" болон ундны усны стандартын шаардлага хангаж байсан бол 2023 оны 4, 7-р саруудад аммонийн азотын агууламж нь "Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998" стандартад заасан хэмжээнээс их байна.



Зураг 11. Нарангийн булгийн эхийн орчим

Нарангийн булаг оршуулгын доор: 2023 оны 4-р сард усгүй байсан учир 2022 болон 2023 оны 7-р сарын дүнг харьцуулан үзэв. Тус булгийн дунд хэсгээс авсан ус нь химийн

найрлагын хувьд өөрчлөлтгүй, гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, цэнгэг, зөөлөвтөр устай байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Нарангийн булгийн усны химийн шинжилгээний дүн, мг/л

Сорьц авсан газрын нэр	Сорьц авсан хугацаа	Эрдэс, мг/л	Хатуулаг (мг-экв/л)	ГИЧ	NH ₄ ⁺	NO ₂ /NO ₃	Индекс	Үндсэн элементүүд					
								CO ₃ ⁻ /HCO ₃ ⁻	Cl ⁻	SO ₄ ²⁻	Na ⁺ +K ⁺	Ca ²⁺	Mg ²⁺
MNS 4586:1998				10	0.6 4	0.065 /39.9		-	300	100	-	-	-
Нарангийн булаг эх	2022.07	293	3.16	1.60	0.0	0.0/1.0	C _{CaI}	0/201.3	6.0	13	13.7	49.7	8.3
	2023.04	308	3.28	1.28	0.5	0.0/10	C _{CaI}	0/201.3	7.1	14	14.8	51.7	8.5
	2023.07	309.5	3.15	1.76	0.7	0.0/8	C _{CaI}	0/192.2	8.2	24	18.9	49.1	8.5
Нарангийн булаг оршуулгын доор	2022.07	387.3	3.78	1.28	0.0	0.0/2.0	C _{CaI}	0/268.4	8.5	14	27.2	53.9	13.3
	2023.07	412.4	4.15	1.44	0	0.0/8	C _{CaI}	0/262.3	10.7	30	27.7	59.1	14.6
Нарангийн булаг гэр хороолол	2022.07	631.4	7.02	2.08	0.0	0.05/12	C _{CaII}	0/329.4	32	98	34.9	101.0	24.1
	2023.07	642.9	6.41	2.08	0	0.02/25	C _{CaII}	0/323.3	36.2	92	51.3	94.4	20.7

Булгийн ус физик, хими болон бичил элементүүдээрээ “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998” болон ундны усны стандартын шаардлага хангаж байна.



Зураг 12. Нарангийн булаг оршуулгын доор

Нарангийн булаг гэр хороолол дунд: 2023 оны 4-р сард усгүй байсан учир 2022 болон 2023 оны 7-р сарын дүнг харьцуулан үзэв. Тус булгийн адаг хэсгээс сорьц авч хэмжилт хийхэд химийн найрлагын хувьд өөрчлөлтгүй, гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, цэнгэгдүү, хатуувтар-хатуу устай байна (Хүснэгт 7). Булгийн ус физик, хими болон бичил элементүүдээрээ “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998” болон ундны усны стандартын шаардлага хангаж байна. Булгийн ус урсгалынхаа дагуу эрдэсжилт, хатуулаг, нитратын ион нь нэмэгдсэн зүй тогтол ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, булгийн эхийн ус цэнгэг, зөөлөвтөр байснаа урсгалынхаа дагуу өөрчлөгдөж гэр хорооллын дундуур урсах хэсэгтээ цэнгэгдүү, хатуу (2022) болж эрдэсжилт, хатуулгийн хэмжээ 2 дахин нэмэгдсэн байна. Мөн нитратын ион гэр хорооллын дундуур урсах булгийн усанд нэмэгдсэн байгаа нь ахуйн бохирдолттой холбоотой байна (Хүснэгт 7).



2022.07



2023.07

Зураг 13. Нарангийн булгийн гэр хороолол дунд урсаж буй байдал

Сувгийн ус

Сувгийн уснаас (18-р цэгийн баруун талд, Шинэ сувгийн далан доторх тогтоол ус, 19-р цэгийн ойролцоо урсгалтгүй тогтоол ус) 2 цэгээс сорьц авсан. Сувгийн усны температур 26.6-27.4°C-ын хооронд байгаа бол усны орчин сул шүлтлэг рН 8.12-8.30 байна.

Хүснэгт 8. Сувгийн усны химийн шинжилгээний дүн, мг/л

Сорьц авсан газрын нэр	Сорьц авсан хугацаа	Эрдэс, мг/л	Хатуулаг (мг-экв/л)	ПИЧ	NH ₄ ⁺	NO ₂ /NO ₃	Индекс	Үндсэн элементүүд					
								CO ₃ ⁻ /HCO ₃ ⁻	Cl ⁻	SO ₄ ²⁻	Na ⁺ +K ⁺	Ca ²⁺	Mg ²⁺
MNS 4586:1998				10	0.64	0.065/39.9		-	300	100	-	-	-
18-р цэгийн баруун талд, Шинэ сувгийн далан доторх тогтоол ус	2023.7	411	2.60	3.84	1.8	0.60/20	X _{Ca+Na} II	0/97.6	32.7	65	34.6	40.1	7.3
19-р цэгийн ойролцоо урсгалтгүй тогтоол ус	2023.7	430.3	3.40	3.52	1.0	0.50/18	SCI ^{Na+} _{Ca} II	0/82.4	71.4	128	66.1	55.1	7.9

18-р цэгийн баруун талд, Шинэ сувгийн далан доторх тогтоол ус: Химийн бүрэлдэхүүнээрээ холимог ангийн, кальци-натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн, органик бус гаралтай бохирдолтой, булингар ихтэй ус байна (Хүснэгт 8).



Зураг 14. 18-р цэгийн баруун талд, Шинэ сувгийн далан доторх тогтоол ус

19-р цэгийн ойролцоо урсгалгүй тогтоол ус: Химийн бүрэлдэхүүнээрээ сульфат- хлорын ангийн, натри-кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр, органик бус гаралтай бохирдолтой, булингар ихтэй ус байна (Хүснэгт 8).



Зураг 15. 19-р цэгийн ойролцоо урсгалгүй тогтоол ус

Газрын доорх ус

Толгойт төслийн талбайгаас нийт 5 худгийн уснаас сорьц авсан. Худгийн усны температур 4.8-12.9°C-ын хооронд байгаа бол усны орчин сул шүлтлэг pH 6.82-7.44 байна. Газрын доорх усны химийн шинжилгээний дүнг Хүснэгт 9-т өгч, худаг тус бүрээр нь үр дүнгийн боловсруулалт хийв.

Хүснэгт 9. Газрын доорх усны химийн шинжилгээний дүн, мг/л

Сорьц авсан газрын нэр	Сорьц авсан хугацаа	Эрдэс, мг/л	Хатуулаг (мг-экв/л)	ПИЧ	NH ₄ ⁺	NO ₂ /NO ₃	Индекс	Үндсэн элементүүд					
								CO ₃ ⁻ /HCO ₃ ⁻	Cl ⁻	SO ₄ ²⁻	Na ⁺ +K ⁺	Ca ²⁺	Mg ²⁺
MNS 0900:2018		1000	7	10	3.0	1.5 /50.0		-	350	500	20 0	10 0	30
Ш.Доржийн худаг	2022.07	1126.2	13.89	2.24	0.0	0.0/120	C ^{Ca} _{III}	0/384.3	133.1	195	49.6	191.4	52.8
	2023.04	1154.7	14.33	5.44	0.0	0.0/120	C ^{Ca} _{III}	0/372.1	130.6	230	50.1	197.4	54.5
	2023.07	1088.6	12.70	1.28	0	0/70	C ^{Ca} _{III}	0/378.2	138.8	210	67	178.4	46.2
“Экстид” ХХК худаг	2022.07	659.2	6.68	1.44	0.0	0.0/17	C ^{Ca} _{III}	0/262.3	111.5	85	64.4	96	23
	2023.04	758	7.93	2.72	0.0	0.0/82	C ^{Ca} _{III}	0/274.5	91.6	105	61.1	120.2	23.5
	2023.07	747.8	7.10	1.44	0	0/30	C ^{Ca} _{II}	0/274.5	95.1	140	80.1	106.2	21.9
Отгонбаярын худаг	2022.07	495.1	5.31	1.60	0.0	0.0/2	C ^{Ca} _{II}	0/298.9	29.8	40	29.8	76.4	18.2
	2023.04	533.6	6.45	2.08	0.0	0.0/14	C ^{Ca} _{III}	0/286.7	28.8	70	17.1	98.2	18.8
	2023.07	542.7	6.10	2.08	0	0/18	C ^{Ca} _{II}	0/277.6	33.7	75	28.8	90.2	19.5
“ТЭСО” ХХК худаг	2022.07	666.7	6.94	1.12	0.0	0.1/18	CCl ^C _{aIII}	0/256.2	121.1	85	62.9	99.4	24.1
“Хүннү конкрет” ХХК худаг	2023.07	670.4	6.45	2.24	0	0/32	C ^{Ca} _{II}	0/311.1	45.4	105.0	60.6	96.2	20.1

Ш.Доржийн худаг: Энэхүү худаг нь СХД-ийн 34-р хороо, Нарангийн гол 60-3 тоот айлын эзэмшилд байх бөгөөд 2013 онд гаргасан, 52 м-ийн гүнтэй, халуун ус болон ойрын айлууд унд ахуйдаа хэрэглэдэг (Зураг 16). Тус худгийн ус нь гидрокарбонат, кальцийн ангийн 3-р төрлийн (7-р сар), гидрокарбонат, сульфатын ангийн, кальцийн бүлгийн, 3-р төрлийн (4-р сар) устай байна. Чанарын хувьд давсархаг, маш хатуу, нийт эрдэсжилт, ерөнхий хатуулаг, кальци, магни, нитратын ионууд нь “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS

0900:2018” стандартын шаардлага хангахгүй байгаа тул хүний унданд хэрэглэхэд тохиромжгүй байна. 2023 оны 7-р сард гол ионуудын агууламж бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна (Хүснэгт 9).



Зураг 16. Ш.Доржийн худаг

“Экстид” ХХК-ны худаг: Энэхүү худаг нь СХД-ийн 20-р хороо, “Экстид” ХХК-ны аж ахуйн хашаанд байрладаг, компанийн 10-аад ажилчин уудаг (Зураг 17). Тус худгийн усны химийн шинжилгээний дүнгээс харахад найрлагын хувьд гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 3-р төрлийн устай байна. Чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтраас хатуу устай байна. Ерөнхийдөө өөрчлөлт багатай байгаа боловч 2023 оны 4-р сард хатуулаг, кальци, нитратын ионууд, 2023 оны 7-р сард хатуулаг, кальцийн ион тус тус “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартаас их байна (Хүснэгт 9). Нитратын бохирдол илэрч байгаа нь худаг хашаа хамгаалалтгүй, гадуураа хог, хаягдалтай ус асгарсан зэргээс үүдэлтэй бөгөөд цаашдаа ч бохирдох эрсдэлтэй байна.



Зураг 17. “Экстид” ХХК-ны худаг

Отгонбаярын худаг: Энэхүү худаг нь СХД-ийн 22-р хороо, Орбит, хилчин 95-1 тоот айлын хашаанд байрладаг, 2011 онд гаргасан, 66 м-ийн гүнтэй (Зураг 18). Ойр орчмын айлууд усаа авч уудаг. Тус худгийн усны химийн шинжилгээний дүнгээс харахад найрлагын хувьд анионоос гидрокарбонатын ион зонхилж, катионоос кальцийн ион давамгайлсан, 3-р төрлийн устай байна. Чанарын хувьд цэнгэгээс цэнгэгдүү, хатуувтар, шинжилсэн

үзүүлэлтүүд нь “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна (Хүснэгт 9). 3 удаагийн шинжилгээний дүнг харьцуулахад өөрчлөлт багатай байна.



Зураг 18. Отгонбаярын худаг

“ТЭСО” ХХК-ны худаг: Энэхүү худаг нь СХД-ийн 20-р хороо, “ТЭСО” ХХК-ны аж ахуйн хашаанд байрладаг (Зураг 19). 2023 онд тус худагас сорьц авах боломжгүй байсан бөгөөд 2022 оны 7-р сарын химийн шинжилгээний дүнгээс харахад найрлагын хувьд анионоос гидрокарбонат-хлорын ион зонхилж, катионоос кальцийн ион давамгайлсан, 3-р төрлийн устай байна. Чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтар, шинжилсэн үзүүлэлтүүд нь “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна (Хүснэгт 9).



Зураг 19. “ТЭСО” ХХК-ны худаг

“ХҮННҮ КОНКРЕТ” ХХК-ны худаг: Энэхүү худаг нь СХД-ийн 20-р хороо, “Хүннү Конкрет” ХХК-ны аж ахуйн хашаанд байрладаг (Зураг 20). 2023 оны 7-р сард тус худагас сорьц авч шинжлэхэд химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р

төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуувар устай байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна (Хүснэгт 9).



Зураг 20. “Хүннү Конкрет” ХХК-ны худаг

5.3.2.2. Толгойт дэд төвийн усны бичил элементийн дүн шинжилгээ

Бичил элементийн дэлгэрэнгүй шинжилгээг “SGS IMME Mongolia” ХХК-ийн лабораторид хийлгэсэн бөгөөд тус дэд төвийн төслийн талбайн судалгаанд хамрагдсан цэгүүдээс Ш.Доржийн худгийн усанд стронций ундны усны стандартаас 1.2 дахин их буюу 2422 мкг/л (2022.07), 1.3 дахин их буюу 2575 мкг/л (2023.04), 1.17 дахин их буюу 2345 мкг/л (2023.07) илэрсэн. Шинэ сувгийн далан доторх тогтоол усанд хөнгөн цагаан 4279 мкг/л (2023.07) буюу 8.5 дахин их илэрсэн бол бусад цэгүүдийн ус бичил элементээрээ стандартын шаардлага хангаж байна. Гэхдээ хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг илүү нарийвчлан авч үзэх шаардлагатай байдаг.

3 удаагийн шинжилгээний үр дүн болон тэдгээрийн дунджаар эрсдэлийн тоон хэмжээг тооцоолов. АНУ-ын Байгаль орчны агентлаг болон Канад Улсын Эрүүл Мэндийн Яамны мэдээллийн санд бүртгэгдсэн (Ba, Cu, Mn, Be, Ni, As, Se, Cd, U, Pb, Zn) бодис тус бүрээр аюулын тоо хэмжээг тооцсон болно. Эдгээр 11 бодисоос хүнцэл (As) хорт хавдар үүсгэдэг, бусад бодисууд нь хорт хавдар үүсгэдэггүй бодисууд юм.

Аюулын тоо хэмжээ 0.2-оос их бол үл хүлцэх эрсдэлтэй байдаг. Үл хүлцэх эрсдэл үүсгэх бодисуудыг 3 удаагийн хэмжилт болон дунджийн түвшинд хэрхэн өөрчлөгдөж буйг Хүснэгт 10-д үзүүлсэн.

Хүснэгт 10. Үл хүлцэх эрсдэлийн түвшин, химийн элементээр

	Бичил элементийн эрсдэлийн үнэлгээгээр үл хүлцэх эрсдэлтэй элемент			
	2022.07	2023.04	2023.07	Дундаж
Сувгийн ус				
19-р цэгийн ойролцоох сувгийн ус	Ni, As	хэмжилтгүй	Ni, As	Ni, As
Шинэ сувгийн далан доторх тогтоол ус	хэмжилтгүй	хэмжилтгүй	Ni, As	Ni, As
Худгийн ус				
Хүннү ХХК-ийн худаг	хэмжилтгүй	хэмжилтгүй	Ni, As,U	Ni, As,U
Эксид ХХК-ийн худаг	Ni, As,U	Ni, As, U	Ni, As,U	Ni, As,U
Доржийн худаг	Ni, As, U	Ni, As, U	Ni, As,U	Ni, As,U
Отгонбаярын худаг	Ni, As, U	Ni, As, U	Ni, As,U	Ni, As,U
Нарангийн булаг				

Нарангийн булгийн эх	Ni, As	As, U	As	Ni, As
Нарангийн булаг, оршуулгын доор	Ni, As, U	хэмжилтгүй	Ni, As,U	As,U
Нарангийн булаг, гэр хороолол дунд	Ni, As, U	хэмжилтгүй	Ni, As,U	Ni, As,U


Үл хүлцэх эрсдэлийн түвшнийг химийн элементээр нь авч үзвэл сувгийн усанд Ni, As үл хүлцэх эрсдэлтэй, худгийн усанд Ni, As, U үл хүлцэх эрсдэлтэй байна. Нарангийн булгийн эх орчим Ni, As давамгайлсан үл хүлцэх эрсдэлтэй, оршуулгын газрын доорх цэгт As, U давамгайлсан үл хүлцэх эрсдэлтэй, гэр хорооллын бүсэд Ni, As, U үл хүлцэх эрсдэлтэй байна.

Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл нь үл хүлцэх эрсдэлтэй Ni, As, U бодис тус бүрээр нь авч үзвэл:

Никель (Ni): Тус элементийн аюулын тоон хэмжээ Эхскид ХХК-ийн худгийн усанд 7.7-8.31, Доржийн худагт хамгийн өндөр буюу 15.6-16.6 байна. Хүннү ХХК-ийн худгийн усанд 2023 оны 07-р сард хийсэн шинжилгээгээр 3.85 байна.

Нарангийн голын эхээс орчмын усны аюулын тоо хэмжээ 2022 оны 7-р сард 2.43 буюу үл хүлцэх, 2023 оны 4, 7-р саруудад хүлцэх эрсдэлтэй байлаа. Тус голын оршуулгын газраас доош болон гэр хорооллын дунд орших цэгийн орчим аюулын тоо хэмжээ үл хүлцэх эрсдэлтэй байна. Өөрөөр хэлбэл Нарангийн голын усан дахь никелийн агууламж доош уруудаж хүний нөлөөлөл ихсэх тусам нэмэгдэж байна.

Гадаргын устай харьцуулахад газрын доорх усны аюулын тоо хэмжээ өндөр гарч байгаа нь геохимийн хуримтлал үүсэж буйг харуулж байж болно. Гэхдээ нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай. Газрын хөрс хөлдүү байх хугацааны сүүлчээр буюу 4-р сард авсан дээжид никелийн агууламж хөрс гэсгэлэн үетэй харьцуулахад бага байна.Энэ нь хөрс хөлдүү үед газрын доорх усанд гадаргаас нэвчих нэвчиц бараг явагддаггүй, гадаргын угаагдал бага байдаг зэрэгтэй холбоотой байж болно.




Зураг 21. Никелийн аюулын тоо хэмжээний орон зай, цаг хугацааны ялгарал

Хүнцэл (As): Эхскид ХХК-ийн худгийн усны аюулын тоо хэмжээгээр 2022 оны 7-р сард $2.3 \cdot 10^{-5}$ буюу үл хүлцэх, 2023 оны 4-р сард $1.2 \cdot 10^{-5}$ буюу үл хүлцэх, 7-р сард $1.6 \cdot 10^{-5}$ буюу үл хүлцэх эрсдэлтэй байна. Доржийн худгийн усны аюулын тоо хэмжээ $2-4.21.2 \cdot 10^{-5}$ буюу үл хүлцэх эрсдэлтэй, Отгонбаярын худаг $1.4-1.71.2 \cdot 10^{-5}$ буюу үл хүлцэх эрсдэлтэй байна.

19-р цэгийн ойролцоох сувгийн усны аюулын тоо хэмжээ $1.6-5.31.2 \cdot 10^{-5}$ буюу үл хүлцэх эрсдэлтэй.

Нарангийн булгийн эх орчмын усны аюулын тоо хэмжээ $1.4-1.71.2 \cdot 10^{-5}$ буюу үл хүлцэх, түүнээс доош гэр хорооллын орчим $2.1-2.41.2 \cdot 10^{-5}$ болж аюулын тоо хэмжээ нэмэгдэж байна.




Зураг 22. Хүнцлийн аюулын тоо хэмжээний орон зай, цаг хугацааны ялгарал

Уран (U): Хүннү ХХК-ийн худгийн усны аюулын тоо хэмжээ 0.69, Экскид ХХК-ийн худгийн ус 0.41-0.51, Доржийн худгийн ус 0.77-0.85, Отгонбаярын худгийн ус 0.21-0.23 байна.

19-р цэгийн ойролцоох сувгийн усны аюулын тоо хэмжээ 0.08-0.12 буюу хүлцэх эрсдэлтэй байна.

Нарангийн булгийн эх орчмын ус 2022 оны 7-р сард 0.19 буюу хүлцэх эрсдэлтэй байсан бол 2023 оны шинжилгээгээр 0.2-0.22 буюу үл хүлцэх эрсдэлтэй байна. Аюулын тоо хэмжээ доошлох тусам нэмэгдэж гэр хорооллын дундаас авсан усны дээжид 0.36-0.41 болсон.



Зураг 23. Хүнцлийн аюулын тоо хэмжээний орон зай, цаг хугацааны ялгарал

5.3.2.3. Толгойт дэд төвийн усны бактериологийн шинжилгээний үр дүн

Бичил амь судлалын шинжилгээг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн лавлагаа лабораторид хийлгэсэн бөгөөд Нарангийн булгийн эхийн усанд нийт нянгийн тоо 100-аас ихгүй байхаас 2022 оны 7-р сард 120 илэрч, 2023 оны 4-р сард 265 илэрч ундны усны стандартаас харгалзан 1.20-2.65 дахин их байна. Харин 2023 оны 7-р сард нийт нянгийн тоо стандартаас хэтрээгүй ч гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо илрэх ёсгүйгээс илэрсэн. 2023 оны 7-р сарын хэмжилтээр Нарангийн булаг, оршуулгын доор нийт нянгийн тоо стандартаас 2 дахин их, Гэдэсний бүлгийн нян, E.coli илрэх ёсгүйгээс илэрсэн, Нарангийн булаг гэр хорооллын дундаас авсан усанд нийт нянгийн тоо стандартаас 2 дахин их, Гэдэсний бүлгийн нян, E.coli, Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян илрэх ёсгүйгээс илэрсэн байгаа нь нянгийн бохирдолттой болохыг илтгэж байна (Хүснэгт 11). 2022 оны 7-р сартай харьцуулахад 2023 оны 7-р сард булгийн ус нянгийн бохирдол ихтэй байна.

Хүснэгт 11. Нарангийн булгийн усны бичил амь судлалын үзүүлэлт

Сорьц авсан худгийн нэр	Сорьц авсан хугацаа	Сорьцод тооцогдох хэмжээ			
		1 мл ННТ	ГБННТ	25 мл ХТГБН	100 мл E.coli
Нарангийн булаг эх	2022.07	120	илрээгүй	илрээгүй	илрээгүй
	2023.04	265	илрээгүй	илрээгүй	илрээгүй
	2023.07	78	илэрсэн	илрээгүй	илрээгүй
Нарангийн булаг оршуулгын доор	2022.07	81	илрээгүй	илрээгүй	илрээгүй
	2023.07	2×10 ²	илэрсэн	илрээгүй	илэрсэн
Нарангийн булаг гэр хороолол	2022.07	98	илрээгүй	илрээгүй	илрээгүй
	2023.07	2×10 ²	илэрсэн	илэрсэн	илэрсэн
MNS 0900:2018 (ЗДА)		<100	0	0	0

Бичил амь судлалын үзүүлэлтээрээ судалгаанд хамрагдсан худгуудаас нийт нянгийн тоо 100-аас ихгүй байхаас иргэн Ш.Доржийн худгийн усанд 2023 оны 4-р сард 152 илэрч, ундны усны стандартаас 1.52 дахин, “Экстид” ХХК худгийн усанд 2022 оны 4-р сард 210 илэрч, стандартаас 2.10 дахин, “Хүннү Конкрет” ХХК-ны худгийн усанд 160 илэрч, стандартаас 1.60 дахин тус тус их байна. Мөн 2023 оны 7-р сард гэдэсний бүлгийн нян илрэх ёсгүйгээс Ш.Доржийн худаг, Отгонбаярын худаг (2023.04-07), “Экстид” ХХК-ны худаг, “Хүннү Конкрет” ХХК-ны худгийн усанд илэрсэн нь нянгийн бохирдолттой болохыг илтгэж байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Худгуудын усны бичил амь судлалын үзүүлэлт

Сорьц авсан худгийн нэр	Сорьц авсан хугацаа	Сорьцод тооцогдох хэмжээ			
		1 мл ННТ	ГБННТ	25 мл ХТГБН	100 мл E.coli
Ш.Доржийн худаг	2022.07	69	илрээгүй	илрээгүй	илрээгүй
	2023.04	152	илрээгүй	илрээгүй	илрээгүй
	2023.07	98	илэрсэн	илрээгүй	илрээгүй
“Экстид” ХХК худаг	2022.07	210	илэрсэн	илрээгүй	илрээгүй
	2023.04	51	илрээгүй	илрээгүй	илрээгүй
	2023.07	99	илэрсэн	илрээгүй	илрээгүй
Отгонбаярын худаг	2022.07	38	илрээгүй	илрээгүй	илрээгүй
	2023.04	73	илэрсэн	илрээгүй	илрээгүй
	2023.07	69	илэрсэн	илрээгүй	илрээгүй
“ТЭСО” ХХК худаг	2022.07	100	илрээгүй	илрээгүй	илрээгүй
“Хүннү Конкрет” ХХК худаг	2023.07	160	илэрсэн	илрээгүй	илрээгүй
MNS 0900:2018 (ЗДА)		<100	0	0	0


2.3. ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ОРЧМЫН ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН ХИМИ, ФИЗИК ШИНЖ ЧАНАР

Хөрсний урвалын орчин (pH). Энэ үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэж үздэг.

2022 оны 7-р сарын дээж авсан цэгүүдийн хөрсний дээжийн (n=21) 87.5 % нь дунд зэрэг шүлтлэг, (n=1) 4.2% нь хүчтэй шүлтлэг, (n=2) 8.3% нь сул шүлтлэг орчинтой байна.

2023 оны 05-р сарын дээж авсан цэгүүдийн хөрсний дээжийн (n=1) 5.2 % нь сул шүлтлэг, (n=3) 15.8 % нь дунд зэрэг шүлтлэг, (n=12) 63.2 % нь хүчтэй шүлтлэг, (n=3) 15.8 % нь хүчтэй шүлтлэг орчинтой байна.


2023 оны 07-р сарын дээж авсан цэгүүдийн хөрсний дээжийн (n=2) 9.5 % нь сул шүлтлэг, (n=3) 14.3 % нь дунд зэрэг шүлтлэг, (n=14) 66.7 % нь хүчтэй шүлтлэг, (n=2) 9.5% нь хүчтэй шүлтлэг орчинтой байна.



Зураг 24. Хөрсний урвалын орчин

Хөрсний урвалын орчны 2022 оны дүнг 2023 онтой харьцуулахад шүлтлэг шинж рүү чиглэсэн байна. Энэ нь хаврын шар усны үер болон хур борооны үерийн угаагдалтай холбоотой байж болно.


Хөрсний ялзмаг буюу органик карбон (C). Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодисын гол үүрэг ач холбогдол нь хөрсний физик нөхцөлийг сайжруулдаг, чийгийн багтаамжийг нэмэгдүүлдэг, хамгийн сайн бүтэц үүсэхэд нөлөөлдөг, усанд уусамтгай үржил шимийн бодисуудыг тогтоон барих, хөрсөн дэх биологи ба микробиологийн идэвхийг сайжруулж ургамлын үндэсний хөгжилтийг дэмждэг, хөрсөн дотор явагдах химийн урвалуудад буффер (зохицуулагч)-ийн үүрэг гүйцэтгэдэг, хөрсөн дэх организмын хүнс болон энергийн эх үүсвэр болдог, хөрсний агаар солилцоог сайжруулдаг зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд зэрэг, >5% их ялзмагтай гэж үнэлдэг.



Зураг 25. Хөрсний ялзмагийн агууламж, %

2022 оны 7-р сарын дээж авсан цэгүүдийн хөрсний ялзмагийн агууламжаар (n=3) 12.5 % нь маш бага, (n=13) 54.2% нь бага, (n=8) 33.3% нь дунд зэрэг ялзмагийн агууламжтай байна. 2023 оны 5-р сарын судалгаагаар ялзмагийн агууламж S-11,14,18,20,21, 22, 24, 25 цэгүүдэд бага зэрэг, бусад цэгүүдэд дунд зэрэг байсан бол 2023 оны 7-р сарын судалгаагаар S-3,10,17,19,20,35 цэгүүдэд бага зэрэг, S-24 цэгт их, S-0, S-30 цэгүүдэд маш их, бусад цэгүүдэд дунд зэрэг байна.

Хөрсний цахилгаан дамжуулалт (ЕС). Хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Хөрсөн дэх илүүдэл давс нь хөрс-усны тэнцвэрт байдалд нөлөөлж ургамлын өсөлтийг сааруулдаг. Мөн хөрсний ЕС-ийн үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Хөрсийг ЕС-ээр нь 0.0-0.26 dS/m сул давсархаг, 0.26-0.77 dS/m дунд зэрэг давсархаг, 0.77-1.78 dS/m их давсархаг, 1.78-3.55 dS/m маш их давсархаг, >3.55 dS/m хэт их давсархаг гэж үнэлдэг.




Зураг 26. Хөрсний цахилгаан дамжуулах чанар

2022 оны 7-р сард дээж авсан цэгүүдийн хөрсний дээжүүд цахилгаан дамжуулалтаар (n=12) 50.0 % нь сул, (n=9) 37.5% нь дунд, (n=3) 12.5% нь маш их цахилгаан дамжуулалттай байна. 2023 оны 5-р сард цахилгаан дамжуулах чанараар S-13, S-22 дунд зэрэг давсжилттай, S-8, S-14 цэгүүдэд бага зэрэг давсжилттай, бусад цэгүүдэд давсжилтгүй байсан бол 7-р сард S-22 дунд зэрэг давсжилттай, S-25 бага зэрэг давсжилттай, бусад дээж давсжилтгүй байв.


Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали (P2O5, K2O). Хөрсний азот, фосфор, кали (N, P, K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P2O5) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксицыг агууламжаар нь <2мг/100г бол бага хангамжтай, 2-4мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Хөрсөн дэх калийн исэл (K2O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл (K2O)-ийг агууламжаар нь <10 мг/100г бол бага хангамжтай, 10-20 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг.

2022 оны 7-р сарын дээж авсан цэгүүдийн хөрсний дээжүүдэд хөрсөн дэх фосфорын пентоксид (P2O5)-ийн агууламжаар (n=17) 70.8 % нь бага хангамжтай, (n=7) 29.2% нь сайн хангамжтай байсан. 2023 оны 5-р сард хөдөлгөөнт фосфорын хангамжаар S-1, S-3, S-16, S-22, S-26 дунд зэрэг, S-11, S-21, S-25 хангалттай, S-10, S-18, S-20, S-28 цэгүүдэд их, бусад цэгүүдэд маш их харин 7-р сард S-5 бага зэрэг, S-0,20,22,24,27 дунд зэрэг, S-10,35 хангалттай, S-3,11,18,19,29 их, бусад дээж маш их байв.



Зураг 27. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P2O5)-ийн агууламж

2022 оны 7-р сард дээж авсан цэгүүдийн хөрсний дээжүүдэд хөрсөн дэх калийн исэл (K2O)-ийг агууламжаар (n=2) 8.3 % нь бага хангамжтай, (n=22) 91.7% нь сайн хангамжтай байна. 2023 оны 5-р сард хөдөлгөөнт калийн хангамжаар S-8 дунд зэрэг, S-10, S-11, S-15, S-22, S-26 хангалттай, S-23 цэгт их, S-13, S-28 маш их, бусад дээж бага зэрэг байсан бол 7-р сард S-24,29 дунд зэрэг, S-12,17,30 их, S-0,13,25,34 маш их бусад дээж бага зэрэг байлаа.



Зураг 28. Хөрсөн дэх калийн исэл (K2O)-ийг агууламж

2.3.1. Толгойт дэд төв орчмын хөрсний бичил элементийн мониторингийн үр дүн

Толгойт дэд төв орчмын хөрсөнд агуулагдах онцгой хортой, хортой био-идэвхт хүнд металлуудын статистик үзүүлэлтийг Хүснэгт 13-д үзүүлэв.

Хүснэгт 13. Толгойт орчмын хөрсний онцгой хортой, био-идэвхт хүнд металлын агууламж

Хоруу чанарын ангилал	Элемент	Дундаж	Хамгийн их утга	Хамгийн бага утга	Медиан	Стандарт хазайлт
2022 оны 7-р сар						
Онцгой хортой хүнд металл, ppm	Pb	28.6	59.0	15.0	26.5	10.4
	Cd	0.0	0.0	0.0	0.0	0.0
	As	14.0	24.0	10.0	14.0	3.2
	Cr	8.3	30.0	0.0	6.0	7.7
Хортой био-идэвхт хүнд металлууд, ppm	Cu	19.5	76.0	4.6	16.2	14.0
	Zn	82.5	157.0	45.0	75.0	25.5
	Ni	2.9	25.0	0.0	2.0	5.3
	V	61.5	72.0	44.0	63.5	7.1
	Sr	345.2	710.0	167.0	312.0	117.9
	Mo	0.7	7.0	0.0	0.0	1.6
	Co	6.8	11.0	4.0	7.0	1.8
2023 оны 5-р сар						
Онцгой хортой хүнд металл, ppm	Pb	35.1	56.0	22.0	29.0	13.0
	Cd	0.0	0.0	0.0	0.0	0.0
	As	0.7	6.0	0.0	0.0	1.8
	Cr	25.1	42.0	13.0	24.0	7.6
Хортой био-идэвхт хүнд металлууд, ppm	Cu	28.3	140.0	5.4	19.7	30.6
	Zn	88.9	217.0	50.0	74.0	40.5
	Ni	11.8	16.0	5.0	11.0	3.4
	V	62.6	68.0	55.0	64.0	4.3
	Sr	264.2	384.0	112.0	269.0	73.8
	Mo	0.1	2.0	0.0	0.0	0.5
	Co	7.1	10.0	5.0	7.0	1.4
2023 оны 7-р сар						
Онцгой хортой хүнд металл, ppm	Pb	22.3	37.5	10.8	19.4	8.1
	Cd	0.1	0.2	0.1	0.1	0.0
	As	11.4	28.0	7.0	11.0	4.3
	Cr	21.3	106.0	7.0	15.0	21.7
Хортой био-идэвхт хүнд металлууд, ppm	Cu	22.0	37.9	11.2	19.5	7.5
	Zn	95.4	403.0	53.0	77.0	73.4
	Ni	17.3	130.0	6.9	12.1	26.0
	V	30.7	40.0	22.0	30.0	4.3
	Sr	89.6	203.0	49.7	74.6	40.8
	Mo	1.0	1.9	0.7	0.9	0.3
	Co	7.2	12.4	4.7	7.0	1.9

Онцгой хортой болон хортой био-идэвхт хүнд металлуудын агууламж хөрсний дээж авсан 20-25 цэгүүд болон 3 удаагийн дээжлэлтийн нийт 60-75 тохиолдолд MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан агууламж тохиолдсон элементүүд нь As, Mo, Cu, Zn зэрэг юм. Мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотойгоор Улаанбаатар хотын зам дагууд хар тугалганы агууламж өндөр байдаг. Мөн хоруу чанар өндөртэй элемент юм. Иймээс эдгээр элементийн орон зай, цаг хугацааны тархалтын зүй тогтлыг статистик утгаар нь авч үзэв.

Хүнцэл (As): Хүнцлийн агууламжийн дундаж 0.7-14.0 ppm, далайц 6.0-21.0 ppm, 1.8-4.3 ppm байна.

2022 оны 7-р сард хамгийн их агууламж S-18 цэгийн орчим 24 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 4 ppm-ээр их, хамгийн бага агууламж S-21 цэгийн орчим 10 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

2023 оны 7-р сард хамгийн их агууламж S-8 цэгийн орчим 28.0 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 8 ppm-ээр их, хамгийн бага агууламж S-22

цэгийн орчим 7.0 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

2023 оны 5-р сард хамгийн их агууламж 6 ppm, хамгийн бага агууламж 0 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

Хамгийн их утга ажиглагдсан цэгүүд нь 1210-1220 м өндөрт өргөгдсөн нам дор газар, бага утга ажиглагдсан цэгүүд нь 1240-1260 м өндөртэй байгаа нь хүнцлийн агууламж бороо цасны урсцаар дамжин хотос, хонхор буюу харьцангуй бага өндөржилттэй газарт хуримтлагдаж байгааг харуулж байна. Нөгөө талаас хамгийн бага агууламж ажиглагдаж буй S-21, S-22 цэгүүд нь гэр хорооллын нягтшил багатай газарт байрлана.



S-18 цэгийн орчим



S-21 цэгийн орчим

S-18, S-8 цэгүүд нь гэр хорооллын нягтшил ихтэй, гуу жалгын орчимд байрлаж байна. Тус жалга нь 2022 онд хөрсний дээж авах үед хог хаягдлаар ихээхэн бохирдсон, уруйн үер буудаг гуу жалга байсан бол 2023 онд Толгойт дэд төвийн хүрээнд далан байгуулснаар хог хаягдалгүй болсон байна.

Зэс (Cu); Зэсийн агууламжийн дундаж 19.5-28.3 ppm, далайц 26.7-134.6 ppm, 7.5-30.6 ppm байна

2022 оны 7-р сард хамгийн их агууламж S-13 цэгийн орчим 30 ppm, хамгийн бага агууламж S-8 цэгийн орчим 0 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

2023 оны 7-р сард хамгийн их агууламж S-13 цэгийн орчим 106.0 ppm, хамгийн бага агууламж S-18 цэгийн орчим 7.0 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

2023 оны 5-р сард хамгийн их агууламж S-10 цэгийн орчим 42 ppm, хамгийн бага агууламж S-24 цэгийн орчим 13 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

Молибден (Mo); Молибден агууламжийн дундаж 0.1-7.0 ppm, далайц 2.0-7.0 ppm, 0.3-1.6 ppm байна

2022 оны 7-р сард хамгийн их агууламж S-25 цэгийн орчим 7 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 2 ppm-ээр их, бусад цэгүүдэд 0-1 ppm буюу стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

2023 оны 7-р сард хамгийн их агууламж S-13 цэгийн орчим 1.9 ppm, хамгийн бага агууламж S-1 цэгийн орчим 0.7 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

2023 оны 5-р сард хамгийн их агууламж S-13 цэгийн орчим 2 ppm, хамгийн бага агууламж бусад бүх цэгүүдэд 0-1 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

Цайр (Zn); Цайрын агууламжийн дундаж 82.5-95.4 ppm, далайц 112.0-350.0 ppm, 40.5-73.4 ppm байна

2022 оны 7-р сард хамгийн их агууламж S-10 цэгийн орчим 157 ppm, S-21 цэгийн орчим 45 ppm буюу стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

2023 оны 7-р сард хамгийн их агууламж S-24 цэгийн орчим 403.0 ppm MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 103 ppm-ээр их, хамгийн бага агууламж S-1, S-3 цэгийн орчим 53.0 ppm буюу стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

2023 оны 5-р сард хамгийн их агууламж S-10 цэгийн орчим 217 ppm, хамгийн бага агууламж S-21 цэгийн орчим 50 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

Хар тугалга (Pb): Хар тугалганы агууламжийн дундаж 22.3-35.1 ppm, далайц 26.7-44.0 ppm, 8.1-13.0 ppm байна.

2022 оны 7-р сард хамгийн их агууламж S-18 цэгийн орчим 59 ppm, хамгийн бага агууламж S-21 цэгийн орчим 15 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

2023 оны 7-р сард хамгийн их агууламж S-15 цэгийн орчим 37.5 ppm, хамгийн бага агууламж S-3 цэгийн орчим 10.8 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

2023 оны 5-р сард хамгийн их агууламж S-13 цэгийн орчим 56 ppm, хамгийн бага агууламж S-16 цэгийн орчим 22 ppm буюу MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

Хамгийн их утгууд нь 1216-1222 м өндөржилттэй цэгийн орчим, хамгийн бага утгууд нь 1240-1260 м өндөржилттэй цэгийн орчим тохиолдож байгаа нь хар тугалганы агууламж бороо цасны урсцаар дамжин хотос, хонхор буюу харьцангуй бага өндөржилттэй газарт хуримтлагдаж байгааг харуулж байна. Үүнээс гадна S-13цэг автозамын орчим, S-18 цэг гэр хороолол дундах тээврийн хэрэгслийн эрчим ихтэй шороон зам орчим, S-15 цэрийн ангийн орчим бөгөөд хар тугалганы агууламж тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хийн хаягдлын нөлөөгөөр зам дагуу хамгийн их агууламж тохиолдсон байж болно.

Бичил элемент нь дан ганцаар хөрсний бохирдлыг үүсгэхээс гадна хам байдлаар геохимийн саатал үүсгэдэг. Үүнийг тодорхойлох зорилгоор дээрх 11 онцгой болон хортой бодисуудаар бохирдлын нийлбэр индекс буюу нийлбэр ачааллын индексийг тооцсон.

S-13, S-15, S-18, S-23, S-25 цэгүүдэд бусад цэгтэй харьцуулахад бохиролтой бөгөөд бохирдлын түвшин бага зэрэг ангилалд хамаарч байна.

S-13-р цэгийн орчим: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй, хойд талаар нь дулааны шугамтай. Гэр хорооллын нягтшил бага болов хөндий хотос газар учир гадаргын урсац, тоосонцрын дэгдэлтээр хуримтлал үүсэх боломжтой газар юм. Энэ цэгийн орчим хар тугалга, молибден, зэсийн агууламж MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага боловч бусад цэгтэй харьцуулахад хамгийн их утгатай байна.



Зураг 29. S-13-р цэгийн орчмын харагдах байдал

S-15-р цэгийн орчим: Цэргийн ангийн урд талын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн багатай, гэр хорооллын дундах цэг юм. Энэ цэгт хар тугалганы агууламж бусад цэгтэй харьцангуй хамгийн их, MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.



Зураг 30. S-15-р цэгийн баруун болон зүүн талын харагдах байдал

S-18-р цэгийн орчим: Энэ цэгийн баруун талаар “Монгол менежмент” ХХК-ийн гүйцэтгэж буй далангийн төсөл хэрэгжсэн бөгөөд төсөл хэрэгжихээс өмнө гуу жалга нь хог хаягдлаар бохирдсон байдалтай байсан. Мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй, гэр хорооллын дунд орших цэг юм. Хөрсөн хар тугалга, хүнцлийн агууламж бусад цэгтэй харьцуулахад хамгийн их боловч MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.



Зураг 31. S-18-р цэгийн орчмын харагдах байдал

S-23 цэгийн орчим: Гэр хорооллын дунд оршиж байгаа цэг юм. Энэ цэгээс дээж авч дахин нягтлах шаардлагатай юм.




Зураг 32. S-23 цэгийн орчмын харагдах байдал


S-25 цэгийн орчим: Нарангийн булаг ихэнхдээ шургадаг хэдий ч хур бороо элбэг үед урсдаг. Хог хаягдлаар ихээхэн бохирдсон.



Зураг 33. S-25 цэгийн дээд болон доод хэсэг болон ус урсаж байх үеийн харагдах байдал



Зураг 34. Хөрсний бохирдлын нийлбэр индекс



Зураг 35. Толгойт дэд төв орчмын хөрсний бохирдлын нийлбэр ачаалал

2.4. Толгойт дэд төвийн ургамлын нөмрөл

Толгойтын гэр хорооллын орчимд нийтдээ 25 овог, 57 төрөлд хамаарах 90 зүйл ургамал бүртгэгдэв. Ургамлын бүлгэмдэл зүйн гарал үүслийн хувьд үзэхэд ихэнхдээ хөл газрын ургамлаас бүрдэнэ. Хөл газрын ургамал зүйлийн бүрэлдэхүүнд 29 зүйл бүртгэгдсэн буюу 32%-ийг эзэлнэ. Дараагийн байранд уулын хээрийн гаралтай ургамал 19 зүйл буюу 21%, нугын гаралтай ургамал 15 зүйл буюу 17% юм. Бусад хээрийн, элсний, марцын гаралтай ургамлууд 2-10 зүйлд багтана. Нугын гаралтай ургамлын зүйлүүд ихэнхдээ багахан горхи урсаж буй гуу жалганы хоёр талаар тааралдана.

Амьдралын хэлбэрийн хувьд модлог ургамал 4 зүйлээс (*Caragana leucophloea*, *C.pygmaea*, *C.stenophylla*, *Clematis intricata*) бүрдэнэ. Харин өвс ургамлаас нэг ба хоёр наст ургамлууд 25 зүйл буюу нийт зүйлийн тооны 28 %-ийг, олон наст өвс 58 зүйл буюу 64 %-ийг тус тус эзэлнэ. Мөн 1 зүйл сөөгөнцөр (*Thymus gobicus*), 2 зүйл заримдаг сөөгөнцөр (*Artemisia adamsii*, *A.frigida*) бүртгэгдсэн. Нэг ба хоёр наст ургамлууд ихэнхдээ уулийн ба шарилжийн төрлийн хөл газрын ургамлаас бүрддэг болно. Харин олон наст өвслөг ургамал цөөн арвитай боловч ганц нэгээр тохиолдох бөгөөд бүлгэмдэлд гүйцэтгэх үүрэг нь бага байна.

Экологийн бүлгийн хувьд хамгийн их тархалттай нь хуурай нөхцөлийг илэрхийлэгч ксерофит, ксеромезофит ургамлууд 33 зүйл буюу нийт зүйлийн бүрдлийн 37%, чийгт гарлын буюу мезофит, мезоксерофит ургамал 38 зүйл буюу 42 % -ийг эзлэн тархсан байна. Энэ нь тухайн гэр хороолол байгаа орчны эрүүл газрын ургамалжилт нь уулаараа Чулуусаг алаг өвс- Шивээт Хялганат хээртэй, тэдгээрийн хоорондын хөндий элдэв өвс – үетэнт нугын хээртэй, горхи даган нугатай байсны үлдвэр юм. Бусад давст гарлын (галофит- 8 зүйл), говь, хээр, хангайн бүс нутгуудад өргөн тархмал (клсмополит- 8 зүйл), мөн элсний гаралтай буюу псаммофит ургамлууд цөөн тоогоор тааралдана.


Толгойт дэд төвийн ургамалжилтын судалгааны үр дүн

Хавар ургамал ургалтын эхний үед 4-р сарын сүүлчээр Толгойт ба Шархад районд судалгаа явуулсан. Хаврын байдлаар таримал мод, сөөгний иш мөчир гэсэж шүүс түрэн дотроо тод ногоон өнгөтэй болжээ. Үүнд: Алтан Харгана (*Caragana leucophloea*), Хайлас (*Ulmus pumila*), Улиас (*Populus laurifolia*), Шар Хуайс (*Caragana arborescens*), Авираа Зогдор өвс (*Clematis intricata*) болно.

Өвслөг ургамлаас тэвгэн найлзууртай ургамал болох Галуун Гичгэнэ (*Potentilla anserina*), Үхэр шүлхий Шарилж (*Artemisia pectinata*), Багваахай (*Taraxacum officinalis*), Үлд өвс (*Orostachys spinosa*), Ширэг Улалж (*Carex duriuscula*), Агь шарилж (*Artemisia frigida*), Навтуул Гичгэнэ (*Potentilla acaulis*), залаат ургамлаас Ботууль (*Festuca lenensis*), Том цэцэгт Дааган сүүл (*Koeleria macrantha*), Зогдор Улалж (*Carex pediformis*) зэрэг ургамал цухуйж, бутлалт эхэлсэн байв. Гэхдээ эдгээр нь ихэнхдээ хашаа хорооны энгэр хэсгийн ёроолоор наранд ээвэр газраар ургасан байна.

Өнгөрсөн жилийн ургамлын хагдны байдлыг үзвэл ургамлын босоо үлдсэн хагд маш бага нийт хагдны бүрхцийн ихэнхдээ 1-15%, зарим газартаа 70% (сургуулийн хашаан дотор) байхад унанги хагд нь 5-70% хүртэл хадгалагджээ.


7-р сарын сүүлчээр (22-нд) судалгааны талбайнуудад ажиглалт хийж талбай тус бүрийн ургамал нөмрөгийн тусгаг бүрхэц, зүйлийн тоо, ерөнхий өндөр, үзэгдэл зүйн үе шатуудыг тэмдэглэж өмнөх 2022 оны өгөгдлүүдтэй харьцуулан судлав. Ургамлын бүрхэц (Зураг 36) өмнөх жилийнхээс төдийлөн их өөрчлөгдөөгүй, харин зарим нэг газрууд, тухайлбал цэцэрлэгийн хашаанд өвсөө хадсан, дотор нь хүлэмж байрлуулсан зэргээр зүйлийн тоо бүрэн бүртгэгдээгүй. Айлуудын хоорондын гудамжаар зарим нэг айлууд хадаж хураасан, зарим нэг нь хаалга орчимдоо гудамжинд нэг наст цэцэг тарьж ургуулсан байв.



Зураг 36. Ургамлын үржлийн ба ургал шатны зүйлүүдийн эзлэх хувийн жин, %


(А-үржлийн шатны, Б-ургал шатны)

Талбай тус бүрт ургах ургамлын зүйлийн тоо S- 11 ба S-28 дугаар цэгүүдэд 2023 онд 6-14 зүйл нэмэгдэж бусад талбайнуудад ганц нэг зүйл илүү бүртгэгджээ.



Зураг 37. Ажиглалтын талбайн ургамлын зүйлийн тооны хэлбэлзэл, ширхэг

Ургамлын үржлийн үе шат буюу бундуйлах, цэцэглэх, үрлэх үе шатанд байгаа зүйлүүдийн хувийн жинг %-оор гаргаж үзвэл үржлийн үе шатны ургамлын зүйлүүд ажиглалтын 2 жилд маш өндөр 90-100%-д хэлбэлзэж, зарим нэг талбайд (S-1, S-20, S-26) үржлийн ба ургал шатны зүйлүүд бараг адилхан тоотой байна. Энэ нь эдгээр талбайнуудад хавар эрт 5 сарын сүүлч, 6 сарын эхээр цэцэглэж үржиж гөвдөг Ширэг улалж, зуны турш байнга ургал байдалд байдаг Хиаг зэрэг ургамлууд хамаарна. Харин Лууль болон Шарилжууд 8 сарын сүүлч ба 9 сарын туршид цэцэглэж тоосоо гүвэх учир энэ үед л тэдгээр ургамлаас амьсгалын замын харшил үүсэх магадлалтай.




Зураг 38. Ургамлын үржлийн ба ургал шатны зүйлүүдийн эзлэх хувийн жин, %

(А-үржлийн шатны, Б-ургал шатны)

2023 онд буюу энэ жил нэмэгдсэн зүйлүүд: Polygonum aviculare, Stellaria gramineum, Pulsatilla turczaninovii, Brassica campester, Erodium cicutarium, Carum buriaticum, Convolvulus ammanii, Saussurea salicifolia зэрэг нийт 8 зүйл нэмэгдэн ургаж байв. Ер нь тухайн нэг газрын ургамлын аймгийг илрүүлэхэд 3-5 жилийн ажиглалт шаардлагатай байдаг. Учир нь зарим зүйлүүд гантай жил ургахгүй өнжих, хур элбэгтэй жил зүйлийн тоо олшрох зэрэг шалтгаан байдаг билээ. Ийнхүү 2022 ба 2023 оны 2 жилийн хугацаанд хамгийн олон 35 зүйлтэй талбай S-0 буюу цэцэрлэгийн хашааны зүлэгжүүлсэн талбай юм.

2.5. Толгойд дэд төв орчмын амьтдын тархалт

Зорилтод байршилд 2023 оны 4 дүгээр болон 10 дугаар сарууд мониторинг судалгаагаар нийт 296 шувуу, хөхтний зүйлүүдийг бүртгэж, тэмдэглэсэн байна (Зураг 39).



Зураг 39. IV болон X сард ажиглаж бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүд.

Энэ удаагийн 2023 оны тандалт судалгаагаар нэгэнт тогтоосон хяналтыг цэгүүдээр тохиолдсон хөхтөн, шувууны зүйлүүдээс үзвэл нийт 20 цэгт 2023 оны 4 дүгээр сард нийт 128 зүйлийн хөхтөн, шувуу бүртгэснээс 90%)n=115(шувуу, 10%)n=13(хөхтөн байсан бол 2023 оны 10 сарын хээрийн ажиглалтаар нийт 97 зүйлийн хөхтөн, шувуу бүртгэснээс 89%)n=86(шувуу, 11%)n=11(хөхтөн байжээ (график 2).

Толгойт дэд төвийн мониторингийн цэгүүдээр ажиглагдаж байгаа хөхтөн шувууны элбэгшил болон тархалт харилцан адилгүй бөгөөд тухайлбал, улирлаар ялгаатай байхаас гадна зарим хүний суурьшлын бүсээс хамааран тодорхой зарим цэгүүдэд бусад цэгүүдтэй харьцуулахад харьцангуй бага байх нөхцөл ажиглагдаж байна (Зураг 40).




Зураг 40. IV сард мониторингийн цэгт бүртгэсэн хөхтөн, шувууны тоо.

Толгойт дэд төвийн 4 сарын мониторингийн ажиглалтаас үзвэл хаврын тачир нөхцөлөөс шалтгаалан үзэгдэж, харагдах амьтны тоо харьцангуй хомс байхаас гадна 1, 15, 18, 23, 25 болон 27 цэгүүдэд түгээмэл тархалттай шувуудын тоо харьцангуй илүү байна. Харин хөхтний хувьд, нохой, муур, магадгүй адуу мал аль ч цэгүүдэд цөөн байгаа нь идэш тэжээл эрэн хайж ийш тийш тэнэж гүйдэг зэрлэг амьтдын зан төрхтэй ижил төстэй байгаа явдал харагдаж байна.


Гэтэл 10 сард Толгойт дэд төвийн орчимд, хяналтын мониторинг цэгүүдэд бүртгэсэн хөхтөн, шувууны хувьд 4 дүгээр сарынхтай харьцуулахад элбэг байсан нь зун харьцангуй хур бороотой, төдийгүй намар таатай удаан, дулаан үргэлжилсэнтэй холбоотой байж болно. Мөн өглөө аль цэгээс эхэлж мониторинг хийснээс шалтгаалан ажиглагдаж байгаа шувуудын зүйлийн баялаг болон элбэгшлийн тоо тухайн байршилдаа харьцангуй өсөх хандлагатай байж болзошгүй нөхцөл Толгойт дэд төвийн өмнөд хэсгийн цэгүүдэд ажиглагдсан (график 3).

Харин эзэнгүй буюу золбин нохой, муурын тоо аль ч дэд төвийн улирал, цаг хугацаанаас хамаарч төсөөлж байснаас буюу Улаанбаатар хотоос мэдээлж буйгаас харьцангуй цөөн, хомс байж болзошгүйг бидний мониторинг хугацаанд тэмдэглэсэн нохой, муурын тооноос урьдчилсан дүгнэлт хийж болохоор байна (Зураг 42).



Зураг 41. X сард мониторингийн цэгт бүртгэсэн хөхтөн, шувууны тоо.

Ажиглалтын мэдээнээс харвал 10 дугаар сард Толгойт дэд төв орчмын мониторингийн цэгүүдээс элбэгшлийн дарааллаар 20, 1, 14, 25% 26, 7, 16 байршлуудад шувуудын зүйлүүдийн тоо харьцангуй бусдаасаа олон төдийгүй баялгийн хувьд ч нэмэгдсэн нөхцөл ажиглагдаж байна. Толгойт дэд төвийн цэгүүдэд зүйлийн баялгийн хувьд ажиглагдсан байдлаас үзвэл 5 зүйлийн шувуу бор шувуу, хан болон хар хэрээ, хөхвөр тагтаа, алаг шаазгай, улаан хошуут зэрэг суурин шувуудаас гадна гэрийн тэжээмэл тахиа хашааны гудмаар бэлчиж байсан нь ажиглагдсан байна (Зураг 42).




Зураг 42. X сард мониторингийн цэгт бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүд ба тоо.


Хүнтэй ойр амьдардаг синантррп шувуудын зүйлүүд оронгийн бор шувуу, хар хэрээ, хон хэрээ, хөхвөр ба хадны тагтаа, алаг шаазгай болон улаан хошуут зэрэг шувуудаас хэрээнүүд бохирдлын зэргийг илэрхийлэгч төдийгүй бусад жижиг дууч, жиргээч шувуудын өндөг, ангаахайг идэж сүйтгэдэг элдэв идэшт шувуудын тоонд багтана. Тэдний олшрол бохир, хог хаягдал элбэгтэйг илэрхийлдэг. Харин жижиг дууч, жиргээч шувууд хотжилт, ногоон байгууламжийн хүрээлэн буй орчны цэвэр байдлыг илэрхийлнэ. Оронгийн бор шувуу тэдгээрийн нэг боловч нэг зүйлийн олон шувуу тийм байдлыг дангаар илэрхийлэх боломжгүй. Тухайлбал, бусад зүйлүүдийн баялаг нэмэгдэж байвал хүрээлэн буй орчны нөхцөл сайжирч мод, сөөгийн тоо нэмэгдэж байгааг илэрхийлнэ.

Хүснэгт 14. Мониторингийн цэг дэх шувуу, хөхтний элбэгшил


2023.10.23			2023.04.16		
Цэг	шувуу	хөхтөн	Цэг	шувуу	хөхтөн
1	14	1	1	5	1
3	7	3	3	0	1
7	5	0	7	0	0
10	1	0	10	1	0
11	3	2	11	1	0
13	0	1	13	2	0
14	12	1	14	2	0
15	4	0	15	8	0
16	7	1	16	0	0
18	0	1	18	5	2
19	3	0	19	2	0
20	31	0	20	0	1
21	4	1	21	0	0
22	1	3	22	3	2
23	1	1	23	9	1
24	0	0	24	5	1
25	12	1	25	25	0
26	7	1	26	1	1
27	4	0	27	7	0
28	0	0	28	1	0




Зураг 43. Бүртгээдсэн хөхтөн, шувууны зүйлүүдийн тархалт (IV сар)
нохой, хэрээ,, улаан хошуут, муур




Зураг 44. Бүртгээсэн хөхтөн, шувууны зүйлүүдийн тархалт (IV сар)
бор шувуу, тагтаа, адуу болон жижиг шувууны үүр.



Зураг 45. Бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүдийн тархалт (Х сар)
шонхор, бор шувуу, хэрээ, тагтаа, улаан хошуут, алаг шаазгай.



Зураг 46. Бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүдийн тархалт (Х сар)
муур, мэрэгч, нохой.



Зураг 47. Бүртгэсэн хөхтөн, шувууны зүйлүүдийн тархалт (Х сар)
адуу (хомоол)

2.6. Төслийн талбайн нийгэм, эдийн засгийн товч тодорхойлолт

Толгойт дэд төвийн газар нутагт хамаарах хороонуудад оршин суугаа хүн амын тоо 40814 байна.

Хүснэгт 15. Толгойт дэд төвийн газар нутагт хамрагдах хүн амын тоо

Хорооны нэр	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
1-р хороо	14745	14569	15159	14179	9483	9566	9293	9753	9558
2-р хороо	14343	14037	13589	14491	8987	9222	9070	8624	8035
3-р хороо	10942	11091	11365	10171	9335	9568	9395	9290	9261
20-р хороо	7130	6863	6643	6639	6912	7156	7598	7454	7732
35-р хороо					5215	5557	5387	5693	5927

СХД-т ядуу хүн амын тоо их байна. Нийт өрхийн 26.2 хувь буюу 148.6 мянган хүн ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байгаа нь дүүргийн хүн амын 46 хувь болж байна. Ядуу хүн ам хамгийн ихтэй хороодод 22, 26, 7, 24-р хороод орж байна. Сүүлийн 4 жилийн хугацаанд нийгмийн халамж авагчдын тоо (давхардсан тоогоор) 74 хувиар, халамжийн зардлын хэмжээ 67 хувиар нэмэгджээ. 2019 оны байдлаар нийт хүн амын 45% нь халамжид хамрагдаж, нэг хүнд дунджаар жилд халамжийн 288.5 мянган төгрөг ногдож байна. Гэсэн хэдий ч иргэд бэлэн халамж авах дуртай, ажил хийх сонирхолгүй, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдахдаа хойрго, ажилд зуучлан оруулдаг боловч тогтвортой ажилладаггүй, төрөөс өгч байгаа халамжид найдаж, ядууралтайгаа эвлэрч амьдрах хандлагатай байна.

Хүн амын өсөлттэй холбоотойгоор эмнэлгийн байгууллага, эмч, ажилтнуудын ачаалал нэмэгдсэн. Эмч мэргэжилтнүүд чадавхжуулах сургалтад бага хамрагддаг, тэдний нийгмийн хамгааллын асуудал шийдэгдээгүй, эмч, сувилагч, ажилтнуудын 69% нь гэр хороолол болон түрээсийн орон сууцад амьдардаг байна.

Халдварт өвчний гаралт/дэгдэлт 2015-2017 онд өндөр байсан байна. Тухайлбал, 2015 онд улаан бурхан, 2016 онд гар хөл амны өвчин, шинээр илэрсэн сүрьеэ, 2017 онд салхин цэцэг, 2018 онд цусан суулга хамгийн их гарсан байна. УБ хотод 2018 онд шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн нийт тохиолдлын хамгийн өндөр тоотой тохиолдол СХД-т буюу 530 өвчлөл бүртгэгджээ. Дүүргийн хэмжээнд халдварт өвчний дэгдэлт их байгаад нэг талаас агаар, орчны бохирдол, ундны ус ариун цэврийн байгууламжийн баталгаагүй байдал, халуун усны газрын хүрэлцээгүй байдал, халдварын дэгдэлтийн үечлэл нөлөөлсөн бол нөгөө талаас иргэдийн эрүүл мэндийн боловсролын хангалтгүй байдал, хувь хүний хариуцлага сул, ядуурал их байгаатай холбоотой байна. Нас баралтын голлох шалтгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл, хавдар, хоол боловсруулах замын өвчин, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл орж байна. Нас баралтын коэффициентоос харахад нялхсын нас баралт 2018 онд 1000 хүүхэд тутамд 12 болж, 2010 оноос 5 дахин, 2015 оноос 3-аар буурсан байна. Дүүргийн хэмжээнд 1-5 насны хүүхдийн нас баралт буурч байгаа боловч эх, хүүхдийн эндэгдлийн түвшин бусад дүүргүүдтэй харьцуулахад өндөр хэвээр байна. Үүнд оношилгооны тоног төхөөрөмжийн хангалт дутмаг, эмч, сувилагч, ажилтнуудын тогтворгүй байдал, эхчүүдийн эрүүл мэндийн боловсрол муу нь нөлөөлж байна. Мөн 1-5 насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд бусдад зодуулах, гэмтэх, түлэгдэх шалтгаанууд орж байгаа нь эцэг, эхийн хүүхдээ үл хайхрах байдал, ядуурал, амьдралын буруу хэвшил их байгаатай холбоотой байна.

СХД-т байрлах төрийн өмчийн 51 цэцэрлэгийн орны хүчин чадлын багтаамж 10915 хүүхдийнх боловч 19340 хүүхэд хүмүүжиж байна. СХД-т 1958-2019 онд ашиглалтад орсон төрийн өмчийн нийт 20 ЕБС байгаа боловч бүх сургууль өөрийн хүчин чадлаас 2-3 дахин хэтрэлттэй сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Хэдийгээр сургуулиуд 3 ээлжээр хичээллэхгүй байгаа боловч ЕБС-ийн анги танхимын дүүргэлт их, нэг ангид олон хүүхэд хичээллэдэг учраас багшийн ачаалал нэмэгдэж, сургалтын чанарт сөргөөр нөлөөлдөг байна. Дүүргийн нутаг дэвсгэр дэх суурьшлын бүс тэлсэн учраас хүүхдийн гэрээс сургууль хүртэл зорчих зай 3 км ба түүнээс их байх тохиолдол байна. Ингэж холоос зорчих үед хүүхэд зам тээврийн осолд өртөх эрсдэлтэй төдийгүй захын гэр хорооллын суралцагчдыг төвийн байшин хорооллын үе тэнгийн суралцагчид ялгаварлах, дээрэлхэх үзэгдэл элбэг тохиолддог байна. СХД-ийн ЕБС төгсөгчдийн ЭЕШ-ын оноо улсын 21 аймаг, 9 дүүргээс 28 дугаар байранд орж байгаа нь хүүхдүүдийн цаашдын амьдралын чанарт нь сөргөөр нөлөөлж байна. Боловсролын чанар муу байгаа нь багшлах боловсон хүчний мэдлэг, ур чадвар, ажлын байрны тогтвор суурьшил, ажлын ачаалал, цалин хөлс болон эцэг эхийн хүүхдэдээ тавих анхаарал, амьдралын нөхцөл байдалтай холбоотой асуудал болж байна.

Ундны ус түгээх цэгийн тоогоороо СХД нь нийслэлийн бусад дүүргүүдээс хамгийн өндөр байгаа бөгөөд 1000 өрхөд 2.5 ус түгээх цэгийн тоо ногдож байна. Энэ нь хамгийн их өрхтэй БЗД-тэй харьцуулахад 1.6 дахин өндөр байна. Гэхдээ дүүргийн зарим хороонд гуу, жалга их байдагтай холбоотойгоор өрхөөс ус түгээх цэгт хүрэх зай зарим хороодын айл өрхийн хувьд алслагдсан байна. Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй өрхийн тоогоороо СХД нь бусад дүүргүүдээс хамгийн өндөр байгаа буюу нийт өрхийн 76.9% нь уламжлалт нүхэн жорлонтой байна. Айл өрхүүд намагтай газар болон үерийн эрсдэлтэй гуу жалганд амьдрах явдал их байна. Үргэлжлэн орсон борооны улмаас үерийн далан, гуу жалга сэтрэх, ус ундардаг намагтай газруудад иргэд усанд автах эрсдэлтэй нөхцөлийг үүсгэж байна.

СХД-ийн нийт хүн ам 2018 оны эцсийн байдлаар 321.2 мянга байгаагийн 38.4% нь эдийн засгийн идэвхтэй хүн ам, 33.6% нь эдийн засгийн идэвхгүй хүн ам байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2018 онд 48,1% байгаа нь Улаанбаатар хотын дундаж түвшнээс харьцангуй доогуур бөгөөд уг үзүүлэлтэд сүүлийн 7 жилийн хугацаанд огцом өөрчлөлт гараагүй байна. Ажилгүйдлийн түвшин 2018 оны байдлаар 9.9 хувь байгаа нь ажилгүйдлийн

түвшин өндөртэй 3 дахь дүүрэг болж байна. СХД-т шилжилт хөдөлгөөн их, түр оршин суугч, хөдөө орон нутгийн хаягтай иргэд олон байгаа нь ажилгүйчүүдийн тоог нэмэгдүүлж байна. ХХҮХ-т ажлын байрын захиалга ирдэг боловч ажил хайгч иргэдийн ур чадвар, мэргэжлийн дадлага, туршлага нь захиалгад тохирдоггүй, иргэд тогтвортой ажиллах хүсэлгүй, ажлын байрны нөхцөл, цалин хөлсийг голдог, ажлын ачаалал даах чадваргүй, бэлэн халамж авах илүү сонирхолтой байдаг байна.


СХД-ийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалтын гол өсөлтийг хүнсний салбарын өсөлт хангаж байна. 2018 онд өмнөх оныхоос үйлдвэрлэлийн хэмжээ 57%-р, борлуулалтын хэмжээ 40%-р өссөн үзүүлэлттэй байна. Дүүргийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мах, загас, жимс ногоо, өөх тос боловсруулалт, үр тарианы гурил, малын тэжээлийн үйлдвэрлэл голлох байр суурийг эзэлж байна. Тус дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг өндөр болон дундаж орлоготой аж ахуйн нэгжүүд дүүргийн төсөвт орлого бүрдүүлдэггүй. СХД нь төсвийн татаас авдаг цөөхөн дүүргийн нэг учраас санхүүгийн хязгаарлагдмал нөөцийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Дүүргийн төсвийн орлого 2018 онд 21.6 тэрбум төгрөг болсны 61.4 хувийг татварын орлогоор бүрдүүлсэн бол, төсвийн зарлага 16.2 тэрбум төгрөг болсны 22.6 хувийг цалин, урамшуулал, нэмэгдэлд зарцуулсан. СХД нь нийслэлээс татаас авдаг учир дүүргийн урсгал зардлыг хамгийн бага хэмжээгээр хянаж, төсөвлөдөг, зөвхөн дүүргийн ОНХС-д шилжүүлгээр 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө 2019 онд орж ирсэн. Энэ хөрөнгийг хороо бүрд хуваарилахад нэг хороонд 40 орчим сая төгрөг ногдохоор байгаа нь дорвитой бүтээн байгуулалт хийх боломж олгохгүй байна.

3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. УУР АМЬСГАЛД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Толгойт дэд төв төслийн үйл ажиллагаанаас цаг уур, уур амьсгалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойллоо. Зураг 48-д агаар мандлын төлөв байдлаас хамаараад төслийн талбайгаас зонхилох болон уул хөндийн салхины дагуу аливаа бохирдуулагчдын тархаж болох тохиолдлыг харуулаа.



Зураг 48. Төслийн талбайгаас гарсан агаарын массын тархалт (HYSPLIT загвар)

Зураг 48-с үзвэл цаг агаарын тухайн үеийн байдлаас хамаарч төслөөс үүсэх аливаа хорт утаа, тоос тоосонцор, гал түймрийн элемент бүхий эгэл хэсгүүдийн урсгал аль ч зүг рүү тархах боломжтой нь харагдаж байна. Иймд үйл ажиллагаандаа тогтмол хяналт тавьж ажиллах шаардлагатай.

Хүснэгт 16. Уур амьсгалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

№	Болзошгүй нөлөөлөл	Төслөөс үзүүлэх нөлөөлөл		Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
		Бүтээн байгуулалтын үе шат	Бүтээн байгуулалтын дараах үе шат	
А. Бүс нутгийн хэмжээнд				
1	Тоосжилт	Ухагдсан газар болон овоолго шорооноос томоохон газар нутгийг хамарсан агаарын массын алсын зөөгдлөөр тоосжилт шилжих	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд сөрөг нөлөөлөл бага	Хөрсөн бүрхэвч

Б. Улаанбаатар хотын хэмжээнд				
2	Агаарын бохирдол	Дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсний тоосжилт болон хорт хийнүүд тухайн үеийн агаар мандлын тогтворшлоос хамаараад Улаанбаатар хотын аль ч хэсэг рүү зөөгдөн очиж агаарын бохирдлын хэмжээнд нөлөөлнө.	Гэр хорооллын айлын яндангийн тоо буурсан, эвдэрсэн газрын талбай бага байх тул нөлөөлөл бага байна	Агаар орчин
3	Температур, салхины горимыг өөрчлөх	Төслөөс үүсэх аливаа дулаан шингээх гадаргуугийн талбай болон агаарыг бохирдуулагч хий, тоосонцрууд нь агаарын дулааны болон салхины горимд нөлөөлж уур амьсгалын дундаж үзүүлэлтийн горимд нөлөөлнө	Төслийн дараах үе шатанд үүсэн өндөр барилга байгууламж нь салхи температурын горимд нөлөөлж хотын дулааны арлын эрчимжлийг нэмэгдүүлнэ.	Агаар орчин
В. Дүүрэг, хорооны хүрээнд				
4	Агаарын бохирдол	Дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсний тоосжилт болон хорт хийнүүд төслийн талбайн салхин доор байрлалтай газрууд руу шилжиж бохирдлыг ихэсгэнэ	Гэр хорооллын айлын яндангийн тоо буурсан, эвдэрсэн газрын талбай бага байх тул нөлөөлөл бага байна	Агаар орчин
5	Үерийн эрсдэл	Гэр хорооллын дундах жалга, сайр, уулын энгэр газруудаас үер буух эрсдэлтэй. Төслийн үед ухсан газар үерийн эрсдэлийг улам бүр эрчимжүүлж үерийн урсцын адгаар байрлалтай газруудад сөрөг нөлөөлөл үзүүлнэ.	Үерийн далан, шуудуу байгуулснаар төслийн дараах үе шатанд нөлөөлөл буурна.	Хөрсөн бүрхэвч
Г.Төслийн талбайн хүрээнд				
6	Үерийн эрсдэл	Гэр хорооллын дундах жалга, сайр, уулын энгэр газруудаас үер буух эрсдэлтэй. Төслийн талбай уулын энгэр өндөрлөг, налуу ихтэй газраар байрласан тул төслийн үед ухсан газар үерийн эрсдэлийг улам бүр эрчимжүүлж үерийн урсцын дагуу байрлалтай бол төслийн бүтээн байгуулалт эвдрэх, сүйдэх эрсдэл байна.	Үерийн далан, шуудуу байгуулснаар төслийн дараах үе шатанд нөлөөлөл буурна.	Хөрсөн бүрхэвч

3.2. Цэвдэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ

Нөлөөллийн хамрах хүрээг бүс нутаг, хот, дүүрэг, төслийн талбай гэсэн үндсэн 4 түвшинд тодорхойлдог. Энэхүү төсөл нь бүс нутгийн хэмжээнд бараг нөлөө үзүүлэхгүй учир тус тайланд нөлөөллийн хамрах хүрээг хот, дүүрэг, хороо, төслийн талбайн хэмжээнд гэсэн 3 түвшинд тодорхойлсон болно.

Хүснэгт 17. Цэвдэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

№	Болзошгүй нөлөөлөл	Төслөөс үзүүлэх нөлөөлөл		Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
		Бүтээн байгуулалтын үе шат	Бүтээн байгуулалтын дараах үе шат	
А. Улаанбаатар хотын хэмжээнд				
1	Цэвдэг алдрах	Төслийн хүрээнд хийгдэх ажлууд нь (авто зам, барилга байгууламж, шугам, суваг) нь	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд айл өрхүүд ихээр төвлөрч хэт их нягтшил үүсгэснээр	Тухайн бүс нутгийн хөрсний чийг,

		цэвдэг оршин тогтноход сөрөг нөлөөтэй.	цэвдэг алдрах хүчин зүйл болно.	дулааны горим өөрчлөгдөх.
Б. Дүүрэг, хорооны хүрээнд				
2	Цэвдэг алдрах	Төслийн хүрээнд хийгдэх ажлууд нь (авто зам, барилга байгууламж, шугам, суваг) нь цэвдэг оршин тогтноход сөрөг нөлөөтэй.	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд айл өрхүүд ихээр төвлөрч хэт их нягтшил үүсгэснээр цэвдэг алдрах хүчин зүйл болно.	Тухайн бүс нутгийн хөрсний чийг, дулааны горим өөрчлөгдөх.
3	Хөрсний ус газрын гадаргад ил гарах	Газрын гадаргад байшин барилгын суурь ухах үед болон газрын гадаргад янз бүрийн зүйлс суулгах үед хөрсөнд агуулагдаж буй ус газрын гадаргад ил гарах / суваг г.м/	Өвлийн улиралд хөрс хөлдөхөд хөрсний ус шахагдан байшин барилгын суурь хэсэг болон доод хэсгээр нэвчин улмаар тухайн орчиндоо халиа үүсгэх	Тухайн бүс нутгийн хөрс, ургамал, хөрсний чийгийн горим алдагдах.
В. Төслийн талбайн хүрээнд				
4	Хөрсний ус газрын гадаргад ил гарах	Газрын гадаргад байшин барилгын суурь ухах үед болон газрын гадаргад янз бүрийн зүйлс суулгах үед хөрсөнд агуулагдаж буй ус газрын гадаргад ил гарах /ёмкость, суваг г.м/	Өвлийн улиралд хөрс хөлдөхөд хөрсний ус шахагдан байшин барилгын суурь хэсэг болон доод хэсгээр нэвчин улмаар тухайн орчиндоо халиа үүсгэх	Тухайн бүс нутгийн хөрс, ургамал, хөрсний чийгийн горим алдагдах
5	Цэвдэг алдрах	Төслийн хүрээнд хийгдэх ажлууд нь (авто зам, барилга байгууламж, шугам, суваг) нь цэвдэг оршин тогтноход сөрөг нөлөөтэй.	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд айл өрхүүд ихээр төвлөрч хэт их нягтшил үүсгэснээр цэвдэг алдрах хүчин зүйл болно.	Тухайн бүс нутгийн хөрсний чийг, дулааны горим өөрчлөгдөх

3.3. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Толгойт дэд төв төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойллоо.

Хүснэгт 18. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

№	Болзошгүй нөлөөлөл	Төслөөс үзүүлэх нөлөөлөл		Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
		Бүтээн байгуулалтын үе шат	Бүтээн байгуулалтын дараах үе шат	
А. Бүс нутгийн хэмжээнд				
1	Тоосжилт	Ухагдсан газар болон овоолго шорооноос томоохон газар нутгийг хамарсан агаарын массын алсын зөөгдлөөр тоосжилт шилжих	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд сөрөг нөлөөлөл бага	Хөрсөн бүрхэвч Агаар орчин
2	Агаарын бохирдол	Барилга байгууламжийн хүрээн үүссэн тоос тоосонцор салхиар зөөгдөн агаар орчныг бохирдуулах	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд сөрөг нөлөөлөл бага	Агаар орчин
Б. Улаанбаатар хотын хэмжээнд				
3	Температур, салхины горимыг өөрчлөх	Төслөөс үүсэх аливаа дулаан шингээх гадаргуугийн талбай болон агаарыг бохирдуулагч хий, тоосонцрууд нь агаарын дулааны болон салхины горимд нөлөөлж уур амьсгалын дундаж үзүүлэлтийн горимд нөлөөлнө.	Төслийн дараах үе шатанд үүссэн өндөр барилга байгууламж нь салхи температурын горимд нөлөөлж хотын дулааны арлын	Агаар орчин

			эрчимжлийг нэмэгдүүлнэ.	
4	Агаарын бохирдол	Дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсний тоосжилт болон хорт хийнүүд тухайн үеийн агаар мандлын тогтворшлоос хамаараад Улаанбаатар хотын аль ч хэсэг рүү зөөгдөн очиж агаарын бохирдлын хэмжээнд нөлөөлнө.	Гэр хорооллын айлын яндангийн тоо буурсан, эвдэрсэн газрын талбай бага байх тул нөлөөлөл бага байна.	Тухайн бүс нутгийн агаарын чанар өөрчлөгдөнө.
В. Дүүрэг, хорооны хүрээнд				
5	Агаарын бохирдол	Дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсний тоосжилт болон хорт хийнүүд төслийн талбайн салхин доор байрлалтай газрууд руу шилжиж бохирдлыг ихэсгэнэ.	Гэр хорооллын айлын яндангийн тоо буурсан, эвдэрсэн газрын талбай бага байх тул нөлөөлөл бага байна.	Агаар орчин
Г. Төслийн талбайн хүрээнд				
6	Тоосжилт, агаарын бохирдол	Ухагдсан газар болон овоолго шорооноос гадна төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй техник хэрэгслийн хатуу, шингэн түлшний хорт хий, хүлэмжийн хийн эх үүсвэр ихэсдэгийн улмаас байгалийн болон техноген нөлөөллөөр агаарын бохирдол ихсэх магадлал маш өндөр юм	Ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, усалгаа арчилгаа сайжрах тохиолдолд нөлөөлөл багасна	Хөрсөн бүрхэвч, Агаар орчин

3.4. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ

Толгойт дэд төв төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газрын доорх усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойллоо.

Хүснэгт 19. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

№	Болзошгүй нөлөөлөл	Төслөөс үзүүлэх нөлөөлөл		Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
		Бүтээн байгуулалтын үе шат	Бүтээн байгуулалтын дараах үе шат	
А. Бүс нутгийн хэмжээнд				
1	Усны нөөц багасах	Төслийн үйл ажиллагааны явцад газрын доорх усны хэрэглээнээс улбаалан усны нөөц багасах	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд сөрөг нөлөөлөл бага	Усан орчин
Б. Улаанбаатар хотын хэмжээнд				
2	Усны бохирдол	Төслийн бүтээн байгуулалтын үе шатанд газрын доорх ус алдагдах, шатах тослох материал алдагдсанаар гүний ус бохирдох сөрөг нөлөөтэй.	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд сөрөг нөлөө бага	Усан орчин
В. Дүүрэг, хорооны хүрээнд				
3	Усны бохирдол	Төслийн бүтээн байгуулалтын үе шатанд газрын доорх ус алдагдах, шатах тослох материал алдагдсанаар гүний ус бохирдох сөрөг нөлөөтэй	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд сөрөг нөлөө бага	Усан орчин
Г.Төслийн талбайн хүрээнд				
4	Усан нөөц багасах, бохирдох	Төслийн бүтээн байгуулалтын үе шатанд газрын доорх ус алдагдах, бохирдох сөрөг нөлөөтэй.	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд үзүүлэх нөлөөлөл бага	Усан орчин

3.5. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ

Толгойт дэд төв төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойллоо.

Хүснэгт 20. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

№	Болзошгүй нөлөөлөл	Төслөөс үзүүлэх нөлөөлөл		Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
		Бүтээн байгуулалтын үе шат	Бүтээн байгуулалтын дараах үе шат	
А. Бүс нутгийн хэмжээнд				
1	Хөрсний бохирдол	Толгойт орчмын бүсийн шатах, тослох материалаар бохирдсон хөрсийг бүтээн байгуулалтын явцад хуулж, цэвэршүүлэх, солих тул бохирдол буурна	Төслийн үйл ажиллагааны явцад хөрсний бохирдол үүсэх эрсдэлтэй	Хөрсөн бүрхэвч
2	Хөрсний эвдрэл	Барилга, зам, бохирын шугам, өндөр хүчдэл зэргийн байгуулалтын явцад хөрсөн бүрхэвч бүхэлдээ эвдрэлд өртөнө	Төслийн үйл ажиллагааны явцад хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл сул байна	Хөрсөн бүрхэвч
3	Тоосжилт	Ухагдсан газар болон овоолго шорооноос салхи болон техноген нөлөөллөөр тоосжилт дэгдэх	Ногоон байгууламж болон замын төлөвлөлттэй холбоотой тоосжилт үүсэх	Хөрсөн бүрхэвч Агаар орчин
Б. Улаанбаатар хотын хэмжээнд				
4	Хөрсний эвдрэл	Барилга барих болон зам, шугам сүлжээ байгуулах явцад хөрсний эвдрэл эрчимжинэ	Толгойт орчмын Гэр хорооллын бүс дэх эвдрэлд өртсөн газар, шороон замын талбай буурна	Хөрсөн бүрхэвч
5	Агаарын бохирдол	Барилгын ажилтай холбоотойгоор өрсний тоосжилт болон агаарын бохирдол буурна	Гэр хорооллын айл-яндангийн тоо буурна, эвдрэл бүхий талбай багасна	Агаар орчин
В. Дүүрэг, хорооны хүрээнд				
6	Хөрсний эвдрэл	Шороон зам, гэр хорооллын эвдэрсэн хөрс бүхий талбайг дахин төлөвлөнө	Хөрсний эвдрэл бүхий талбайг нөхөн сэргээж сайжруулах, ногоон байгууламж төлөвлөх	Хөрсөн бүрхэвч
7	Хөрсний бохирдол	Барилгын материалын хадгалалт, тээвэрлэлт, газар шорооны ажлын үед хөрсөнд шатах тослох материал, химийн бодис асгарах	Бохирдсон хөрс бүхий талбайг хуулж цэвэрлэх	Хөрсөн бүрхэвч
8	Үерийн эрсдэл	Гэр хорооллын дундах жалга, сайр, уулын энгэр газруудаас үер буух эрсдэлтэй. Ухсан газар үерийн эрсдэлийг улам бүр эрчимжүүлнэ.	Үерийн далан, шуудуу байгуулж, эрсдэлийг бууруулах	Хөрсөн бүрхэвч
Г.Төслийн талбайн хүрээнд				
9	Хөрсний эвдрэл	Шороон зам, гэр хорооллын эвдэрсэн хөрс бүхий талбайг дахин төлөвлөнө	Хөрсний эвдрэл бүхий талбайг нөхөн сэргээж сайжруулах, ногоон байгууламж төлөвлөх	Хөрсөн бүрхэвч
10	Хөрсний бохирдол	Барилгын материалын хадгалалт, тээвэрлэлт, газар шорооны ажлын үед хөрсөнд шатах тослох материал, химийн бодис асгарах	Бохирдсон хөрс бүхий талбайг хуулж цэвэрлэх	Хөрсөн бүрхэвч

11	Үерийн эрсдэл	Гэр хорооллын дундах жалга, сайр, уулын энгэр газруудаас үер буух эрсдэлтэй. Ухсан газар үерийн эрсдэлийг улам бүр эрчимжүүлнэ.	Үерийн далан, шуудуу байгуулж, эрсдэлийг бууруулах	Хөрсөн бүрхэвч
12	Хөрсний элэгдэл эвдрэл	Барилга байгууламжийн үе шатанд хөрсөн бүрхэвч дарагдах, талхидалд өртөх, эвдрэх сөрөг нөлөөтэй.	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл багасна	Хөрсөн бүрхэвч

3.6. УРГАМЛЫН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Толгойт дэд төв” төслийн талбайн ургамлын нөмрөг хүчтэй нөлөөлөлд өртсөн байна. Төслийн үйл ажиллагаанаас ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойллоо.

Хүснэгт 21. Ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

№	Болзошгүй нөлөөлөл	Төслөөс үзүүлэх нөлөөлөл		Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
		Бүтээн байгуулалтын үе шат	Бүтээн байгуулалтын дараах үе шат	
А. Бүс нутгийн хэмжээнд				
1	Ургамлын нөмрөг устгах	Барилга байгууламж бүтээн байгуулалтын явцад ургамлын нөмрөг устгах, төрөл зүйл багасах сөрөг нөлөөтэй	Бүтээн байгуулалтын дараах үе шатанд ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөө бага	Ургамлын нөмрөг
Б. Улаанбаатар хотын хэмжээнд				
2	Ургамлын нөмрөг устгах	Төслийн талбайн ургамлын нөмрөг устаж үгүй болох, талхагдалд орох, зүйлийн тоо буурах сөрөг нөлөөтэй.	Бүтээн байгуулалтын дараах үед ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага	Ургамлын нөмрөг
В. Дүүрэг, хорооны хүрээнд				
3	Ургамлын нөмрөг	Төслийн талбайн ургамлын нөмрөг устаж үгүй болох, талхагдалд орох, зүйлийн тоо буурах сөрөг нөлөөтэй.	Барилга байгууламж барих тээвэрлэх үе дууссаны дараа ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл багасна	Ургамлын нөмрөг
Г. Төслийн талбайн хүрээнд				
4	Ургамлын нөмрөг устгах	Төслийн талбайн ургамлын нөмрөг устаж үгүй болох, талхагдалд орох, зүйлийн тоо буурах сөрөг нөлөөтэй.	Бүтээн байгуулалтын дараа үе шатанд ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл багасна	Ургамлын нөмрөг

3.7. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Толгойт дэд төв” төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойллоо.

Хүснэгт 22. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн хамрах хүрээ

№	Болзошгүй нөлөөлөл	Төслөөс үзүүлэх нөлөөлөл		Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
		Бүтээн байгуулалтын үе шат	Бүтээн байгуулалтын дараах үе шат	
А. Бүс нутгийн хэмжээнд				
1	Хүн амын өсөлт	Барилга байгууламжийн бүтээн байгуулалтын явцад ажлын байр нэмэгдэх эерэг нөлөөтэй	Бүтээн байгуулалтын дараах үед барилга байгууламжийн ажлын байр нэмэгдэх эерэг нөлөөтэй	Хүн ам
Б. Улаанбаатар хотын хэмжээнд				

2	Хүн амын өсөлт	Барилга байгууламжийн бүтээн байгуулалтын явцад ажлын байр нэмэгдэх эерэг нөлөөтэй	Бүтээн байгуулалтын дараах үед барилга байгууламжийн ажлын байр нэмэгдэх эерэг нөлөөтэй	Хүн ам
В. Дүүрэг, хорооны хүрээнд				
3	Хүн амын өсөлт	Барилга байгууламжийн бүтээн байгуулалтын явцад ажлын байр нэмэгдэх эерэг нөлөөтэй	Бүтээн байгуулалтын дараах үед барилга байгууламжийн ажлын байр нэмэгдэх эерэг нөлөөтэй	Хүн ам
4	Иргэдийн орлого нэмэгдэх	Барилга байгууламжийн бүтээн байгуулалтын явцад ажлын байр нэмэгдсэнээр амьжиргааны түвшин сайжирна	Бүтээн байгуулалтын дараах үед барилга байгууламжийн ажлын байр нэмэгдэж иргэдийн амьжиргааны түвшин сайжирна	Нийгэм эдийн засаг
Г.Төслийн талбайн хүрээнд				
5	Хүн амын өсөлт	Барилга байгууламжийн бүтээн байгуулалтын явцад ажлын байр нэмэгдэх эерэг нөлөөтэй	Бүтээн байгуулалтын дараах үед барилга байгууламжийн ажлын байр нэмэгдэх эерэг нөлөөтэй	Хүн ам
6	Иргэдийн орлого нэмэгдэх	Барилга байгууламжийн бүтээн байгуулалтын явцад ажлын байр нэмэгдсэнээр амьжиргааны түвшин сайжирна	Бүтээн байгуулалтын дараах үед барилга байгууламжийн ажлын байр нэмэгдэж иргэдийн амьжиргааны түвшин сайжирна	Нийгэм эдийн засаг

3.8. БАЙГАЛЬ ОРЧНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ ТОДОРХОЙЛОХ

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлохдоо “Толгойт дэд төв”-ийн барилгын явцад болон барилгын дараах гэж ангилан болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойллоо.

Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бүрэлдэхүүн тус бүрээр тодорхойллоо. Ингэхдээ нөлөөллийн оноот үнэлгээний аргыг ашиглан нөлөөллийн үр дагавар, түүнд өртөх нутаг дэвсгэр болон байгаль орчны чадамжид оноо өгч дүгнэлт гаргав. Шалгуур онооны үзүүлэлтийг дараах байдлаар авч үзэв. Үүнд:

а. Үр дагавар

Байгаль орчны сүйрэл (A1)

Байгалийн нөөц ба хүрээлэн буй орчны чанарт үзүүлэх нөлөө (A2)

Янз бүрийн тохиолдол (A3)

б. Үр нөлөөний хамрах хүрээ

Орон зайгаар (B1)

Үргэлжлэх хугацаагаар (B2)

в. Сөрөг нөлөөллийг даах байгалийн чадавх

Нөхөн сэргээгдэх байдал (C1)

Нөлөөллийг эерэг, сөрөг ба нөлөөлөлгүй гэсэн ангиллаар авч үзнэ. Нөлөөллийн үзүүлэлт ба оноог Хүснэгт 23-д, нөлөөллийн зэргийн шалгуурыг Хүснэгт 24-д тус тус харуулав. Нийлбэр нөлөөллийн зэргийг $H^*(A1+A2+A3+B1+B2+C1)$ томъёогоор илэрхийлэв.

Хүснэгт 23. Нөлөөллийн үзүүлэлт ба оноо

Тэмдэглэгээ	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт	Нөлөөллийг үнэлэх оноо		
		Эерэг (1)	Сөрөг (-1)	Нөлөөгүй (0)
H	Нөлөөлөл	Эерэг (1)	Сөрөг (-1)	Нөлөөгүй (0)
A1	Байгаль орчны сүйрэл	Их (3)	Дунд (2)	Хязгаарлагдмал (1)

A2	Байгалийн нөөц, орчны чанарт учруулах нөлөө	Их (3)	Дунд (2)	Бага (1)
A3	Тохиолдох магадлал	Их	Магадлалтай	Магадлал бага
B1	Нөлөөллийн хамрах хүрээ	Бүсийн	Орон нутгийн	Маш бага талбайд
B2	Үргэлжлэх хугацаа	Урт	Дунд	Богино
C1	Нөхөн сэргээгдэх чадвар	Үл сэргээгдэх	Хэсэгчлэн сэргээгдэх	Бүрэн сэргээгдэх

Хүснэгт 24. Нөлөөллийн зэргийн шалгуур

Сөрөг нөлөөлөл		Эерэг нөлөөлөл	
Их	< -15	Их	+15 <
Дунд	(-15; -9)	Дунд	(+9; +15)
Бага буюу нөлөөгүй	-9 <	Бага	< +9

Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл бүрийн хамрах цар хүрээ болон тохиолдох магадлал хир байгааг өгөгдөл цуглуулах болон өгөгдөлдөө задлан шинжилгээ өгөх замаар шинжилсэн болно. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг байгаль орчны өнөөгийн төлөв байдлын суурь судалгааны үндсэн дээр оноот арга болон үнэлгээний шалгуурын дагуу өгөгдөлд дүн шинжилгээ хийв.

3.9. Болзошгүй сөрөг нөлөөллийн тархалтын түвшнийг тодорхойлох

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлно. Нөлөөллийн хэмжээг тодорхойлох нь тухайн хүний ойлголтоос ихээхэн хамаардаг тул ихэнх тохиолдолд байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр дараах шаардлагыг мөрдөх шаардлагатай. Нөлөөллийн хэмжээг 3 хүчин зүйлээр тодорхойлно. Нөлөөлөл тус бүрд дээр дурдсан хүчин зүйл бүр 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал.

Хэмжээ тархалт (M)	Нөлөөллийн хэмжээг тодорхойлно. (бага, дунд, их) Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хугацааг тодорхойлно. (богино, дунд, урт хугацаа)
Хамрах хүрээ (S)	Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх газар зүйн байрлал, талбай (тухайн талбай орчимд, арай өргөвтөр талбайд, нэлээд өргөн газар нутгийг хамарсан)
Давтамж/магадлал (F)	Дахин давтагдах магадлал ба дахин давтагдах тоо (бага магадлалтай, өндөр магадлалтай, тохиолдол нь тодорхой)

Болзошгүй нөлөөллийг хэмжээ, хамрах хүрээ, давтамж гурвын үржвэрээр тооцно.

$$M \times S \times F = \text{Болзошгүй нөлөөллийн хэмжээ}$$

Нөлөөллийн хамгийн бага хэмжээ 1 (1x1x1), хамгийн их хэмжээ нь 27 (3x3x3) байна. Нөлөөллийн хэмжээ 6-аас доош байгаа тохиолдолд үл мэдэгдэх нөлөөлөл гэж үзнэ. Хүснэгт 25-д хэмжээ, хамрах хүрээ, давтамж гуравт үнэлгээг харгалзуулах журам, нэгдсэн үнэлгээг тооцоолох тухай журмыг харуулсан болно. Хэрвээ тухайн нөлөөлөл хуулийн зохицуулалт хийх шаардлагатай болохоор бол мэдэгдэхүйц нөлөөлөлд тооцогдоно.

Хүснэгт 25. Нөлөөллийг үнэлэх шалгуур

Төрөл/Үнэлгээ	Шалгуур		
	M: Хэмжээ, тархалт		
Түвшин - 1	Бага болон богино хугацааны нөлөөлөл - энэ хоёр нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд		
Түвшин - 2	Дунд зэрэг, эсвэл дунд хугацааны нөлөөлөл - Энэ 2 нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд		
Түвшин - 3	Томоохон, эсвэл урт хугацааны нөлөөлөл - Энэ хоёр нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд		
	Нөлөөллийн түвшин		
Бага зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд бага	Богино хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сарын хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой.

Дунд зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд дунд зэрэг	Дунд хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сараас 2 жилийн хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой.
Томоохон нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд их	Урт хугацааны	Төсөл дууссанаас хойш 2 ба түүнээс дээш жилийн хугацааны дараа нөхөн сэргээгдэх боломжтой.
S: Хамрах хүрээ буюу газар зүйн тархалт			
Үнэлгээ - 1	Нөлөөлөх талбай: Зөвхөн үйлдвэржилтийн талбайн хүрээнд		
Үнэлгээ - 2	Нөлөөлөх талбай: Үйлдвэржилтийн талбайгаас гадагш 500 метрийн радиуст		
Үнэлгээ - 3	Нөлөөлөх талбай: 500 метрийн радиусаас цааш талбайг хамарсан		
F: Давтамж буюу магадлал			
Үнэлгээ - 1	Бага магадлалтай - Санал болгож буй төсөлтэй ижил төслүүдийн хувьд үүсэж байсан, энэ төслийн хувьд бараг тохиолдох боломжгүй		
Үнэлгээ - 2	Дунд зэргийн магадлалтай - Энэ төслийн хувьд тохиолдох боломжтой		
Үнэлгээ - 3	Өндөр магадлалтай - Энэ төслийн хувьд бараг л тохиолдоно		

Хүснэгт 26. Төслийн байгаль орчныг хянах хүснэгт

Нийт түвшин	Үнэлгээ	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээ
Нөлөөллийн түвшин бага	< 6	Бага - Тийм ч анхаарал татахуйц биш
Нөлөөллийн түвшин дунд	18-Jun	Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой.
Нөлөөллийн түвшин өндөр	> 18	Их буюу өндөр - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой
Бууруулж болохуйц нөлөөлөл: Нөлөөлөл нь их боловч тодорхой аргыг хэрэглэснээр нөлөөллийн түвшнийг бууруулах боломжтой.		
Үр дүнтэй (эерэг нөлөөлөл): Нөлөөлөл нь их боловч байгаль орчин, хүний хэрэглээ, хүний үнэ цэнийг сайжруулж чадна.		

Төслийн байгаль орчны асуудлуудыг Хүснэгт 26-д жагсаан харуулаад, дараа нь тэдгээрийн нөлөөллийн хэмжээ, тархалтыг асуудал тус бүрээр нь тооцоолох бөгөөд үүнийг байгаль орчныг хянах эцсийн хүснэгтэд оруулна. Төслийн үйл ажиллагаа, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэлгээ 6 ба түүнээс дээш байх тохиолдолд бүрэн хэмжээнд судална. Харин үнэлгээ 6 ба түүнээс доош байх тохиолдолд судлах шаардлагагүй бөгөөд зөвхөн эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд дараагийн үе шатанд судалж болно. Учир нь, олон жижиг нөлөөлөл нийлээд нэг том нөлөөллийг үүсгэн төслийн ерөнхий эрсдэлд нөлөөлж болно

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, илрүүлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав. БОМТ нь Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь зэргээс бүрдэнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, тайлагнах эрх үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Улаанбаатар хотын захиргаа, түүнийг төлөөлөн төслийг өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж буй ТХН хүлээх бол БОМТ-д заагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах үүргийг барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллагууд хүлээнэ. БОМТ-г хэрэгжүүлэх төсөв зардлыг барилгын ажлын гэрээнд тусган оруулж өгөх бөгөөд гэрээт гүйцэтгэгч байгууллагууд нь барилгын ажлын явцад талбайн байгаль орчны ажилтан авч ажиллуулах үүргийг хүлээнэ.

БОМТ үндсэн зорилгоо хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах бодлогыг баримтална. Үүнд:

1. БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдуулах;
2. БОМТ-ний хэрэгжилтийг компанийн удирдлага өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
3. БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр лабораторийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно.
4. БОМТ-д тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажилчдын үүрэг хариуцлагын тогтоосон удирдлагын шатлал дараалал бий болно.
5. Ажилчид бүр байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, ур чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.
6. Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцож, байгаль орчинд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны чанарыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж, хамгаална.
7. Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана.
8. Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь төсөл хэрэгжих Толгойт дэд төвийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн

хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө, Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө, Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь зэргээс бүрдэнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав. Толгойт дэд төв нь нийт 554.4 га талбайг хамрах ба засаг захиргааны хил хязгаарын хувьд Сонгинохайрхан дүүргийн 1,2,3,20,34,35 дугаар хороодын нутаг дэвсгэрт хэрэгжих юм.

Төслийн хүрээнд шинээр бүтээн байгуулах дараах нийгмийн барилга байгууламж, дэд бүтцийн ажлууд, тэдгээрийн хэрэгжих орчныг энэхүү төлөвлөгөөнд хамруулан авч үзсэн болно. Үүнд:

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 2024 онд хэрэгжих бөгөөд БОМТ-ний биелэлтэд хяналт тавих, тайлагнах эрх үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Улаанбаатар хотын захиргаа, түүнийг төлөөлөн төслийг өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж буй Төслийн Удирдах Нэгж хүлээх бол БОМТ-д заагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах үүргийг барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллагууд хүлээнэ. БОМТ-г хэрэгжүүлэх төсөв зардлыг барилгын ажлын гэрээнд тусган оруулж өгөх бөгөөд гэрээт гүйцэтгэгч байгууллагууд нь барилгын ажлын явцад талбайн байгаль орчны ажилтан авч ажиллуулах үүргийг хүлээнэ.

Толгойт дэд төв төслийн хүрээнд нийт 29 багц ажил хамаарч байгаагаас 2023 оны 12-р сарын байдлаар 21 багц ажил хэрэгжиж эхлээгүй, 4 багц ажил буюу талбайн цэвэрлэгээний ажил дууссан, 2024 онд 20 багц ажлын бүтээн байгуулалт хийгдэхээр төлөвлөж байгаа бөгөөд тухайн төслүүдийн барилгын ажил 1-2 жил үргэлжлэх тул нөхөн сэргээлт, тохижилтын ажил 2025 оноос эхэлнэ.

2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **66,840,758 төгрөг /66 сая 840 мянга 758 төгрөг/** болох бөгөөд зардлын хураангуйг Хүснэгт 27-д ангилан үзүүлэв.

Хүснэгт 27. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Package Number	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	Удирдлага зохион байгуулалт	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөг
1	TRDH11A	837,311	-	-	-	-	450,000	436,095	686,700	-	2,410,106
2	TRDH11B	837,311	-	-	-	-	450,000	436,095	686,700	-	2,410,106
3	TRDH11C	837,311	1,108,021	-	-	-	450,000	436,095	1,920,000	-	4,751,427
4	TRDH11D	837,311	-	-	-	-	450,000	436,095	686,700	-	2,410,106
5	TRDH14A	837,311	-	-	-	-	450,000	436,095	1,117,500	-	2,840,906
6	TRDH14B	837,311	-	-	-	-	450,000	436,095	1,117,500	-	2,840,906
7	TEC-A	766,666	-	-	-	-	700,000	452,761	624,000	-	2,543,427
8	TEC-B	766,666	-	-	-	-	700,000	452,761	624,000	-	2,543,427
9	TEC-C	766,666	-	-	-	-	700,000	452,761	624,000	-	2,543,427
10	TFP-A	900,000	1,000,000	-	-	-	1,000,000	905,523	500,000	-	4,305,523
11	SHTSC-A	477,166	-	-	-	-	700,000	754,602	493,350	-	2,425,118
12	SHTSC-B	477,166	-	-	-	-	700,000	754,602	493,350	-	2,425,118
13	SHTSC-C	477,166	-	-	-	-	700,000	754,602	493,350	-	2,425,118
14	SHTL-A	2,010,195	-	-	-	-	700,000	654,142	516,000	-	3,880,337
15	SHTL-B	1,005,097	-	-	-	-	700,000	654,142	258,000	-	2,617,239
16	SHTL-C	1,005,097	-	-	-	-	700,000	654,142	258,000	-	2,617,239
17	SHTL-D	1,005,097	-	-	-	-	700,000	654,142	258,000	-	2,617,239
18	PHC	1,923,400	-	-	-	-	1,000,000	562,762	670,000	-	3,156,162
19	TBC	1'616'000	7,648,290	-	-	-	1,000,000	715'000	670,000	-	9,318,290
20	TSC	1,801,482	1,725,293	-	-	-	1,000,000	562,762	670,000	-	5,759,537
Нийт төсөв		18,405,730	11,481,604	-	-	-	12,700,000	10,886,274	13,367,150	-	66,840,758

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11 болон TRDH14):

Ажлын нэр	TRDH11A Толгойт дэд төвийн авто зам болон дагалдах ИШС (3-р хэсэг)	TRDH11B Толгойт дэд төвийн авто зам болон дагалдах ИШС (4-р хэсэг)	TRDH11C Толгойт дэд төвийн насос станц болон усан шугам сүлжээ	TRDH11D Толгойт дэд төвийн авто зам	TRDH14A Толгойт дэд төвийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (1-р хэсэг)	TRDH14B Толгойт дэд төвийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (2-р хэсэг)
Авто зам, замын байгууламж	Зогсоол 7618.7м ²	1461м	-	3270 м	1,613.9м зам, зогсоол 516м ²	473.2 м
Бохир усны шугам сүлжээ		3787.5м			1284м	1076м
Төвлөрсөн дулааны шугам сүлжээ					-	1338.5м
Усан хангамжийн сүлжээ			2890м		966.8м	1930м
УДДТ		1Ш	1Ш		УДДТ 2, 3, 4	УДДТ 1, 5
Эвдрэлд өртөх талбай	7618.7м²	20,495.8 м²	4,312 м²	39,240м²	31,129.84	8,967.6

Хүснэгт 28. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TRDH11 болон TRDH14 багцууд)

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Шаардагдах зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Газар шорооны ажлаас нийт 11.17 га талбайн газрын гадарга эвдрэлд өртөнө	Авто зам тавих ажилд өртөж эвдэрсэн 3.97 га талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн сэргээлт, тэгшилгээний ажлууд хийж, хэлбэршүүлэх, орчны тохижилт үүсгэх		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Тухайн цэг дээрх барилгын ажил дуусах үед	Нөхөн сэргээлтийн стандарт MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008
Газар шорооны ажлаас нийт 30,564 м ³ хаягдал шороон материал үүснэ	Газар шорооны ажлаас үүсэх нийт 39,400.96 м ³ Үүсэх бөгөөд үүний 13,726.3 м ³ хэмжээтэй хаягдал шороон материалыг Цагаан давааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг Сонгинохайрхан дүүргийн хот тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө. Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.	Газар шорооны ажил явагдах бүх цэгт	Барилгын ажлын төсөвт багтсан	Газар шорооны ажил явагдах хугацаанд, 7 хоног бүр	Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам MNS BS 5906:2015 Барилгын хог хаягдлын менежмент, ашиглалтын
Гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орно	Авто зам ба дулаан, цэвэр, бохир ус, дренажийн шугам хоолой тавих газар шорооны ажлуудаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрлаж байсан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх	Газар шорооны ажил явагдах бүх цэгт	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Газар шорооны ажил явагдах хугацаанд	MNS5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Газар шорооны ажил, талбайн тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас 925.344	Авто зам ба дулаан, цэвэр, бохир ус, дренажийн шугам хоолой тавих газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд хуурай өдрүүдэд м ² талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох	Газар шорооны ажил явагдах бүх цэгт	3'123'870	Барилгын ажлын туршид	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016

2024 онд Толгойт дэд төвд хэрэгжүүлэх Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө, Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

кг/жил хэмжээтэй тоосжилт үүсэж агаар орчныг бохирдуулах	Хүчтэй салхи шуургатай үед хөрсний овоолгоос тоосжилт үүсэхээс сэргийлж усалгаа хийх	Газар шорооны ажил явагдах бүх цэгт			Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага	
	Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Газар шорооны ажил явагдах бүх цэгт				
Зам барилга, барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал, бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах	Зам барилга, барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх	Зам барилга, барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизм/	Барилгын ажлын төсөвт багтсан	7 хоног бүр	MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2010 Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ	
	Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх				Барилгын ажлын төсөвт багтсан	MNS4990:2000 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
	Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах				ОХШХ-т тусган оруулсан	MNS 5013:2009, MNS5014:2009
Цемент, элс зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд хийсэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй	Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх	Авто зам, барилгын ажил явагдах бүх цэгт	Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид, 7 хоногт 1-2 удаа	Агаарын тухай хууль,	
	Дулааны эх үүсвэр гаргах буюу хаягдал материалыг устгах зорилгоор шатамхай материалыг ил талбайд шатаахыг хориглоно				Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага	
3. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө						
Газар шорооны ажил, зам барилгын ажил, шугам хоолойн угсралтын ажил, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүсэх	Зам барилга ба барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношилгоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох	Зам барилга, барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид	MNS4585:2016 Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ	
	Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх	Барилгын ажлын талбай	ОХШХ-т тусган оруулсан		MNS4995:2015 Ажлын орчинд дуу чимээний давтамж болон хэлбэлзэл	
	Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих					
Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж, зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	Сонгинохайрхан дүүргийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж, түүнд хаягдал шороон материал, ахуйн ба барилгын хог хаягдлыг зайлуулах цэг ба тээвэрлэх автомашины улсын дугаарыг тодорхой зааж өгөх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	Барилгын ажил эхлэх үед, 2024 оны 2-р улиралд	Хог хаягдлын тухай хууль	
	Барилгын ажил явагдаж буй газруудад хогийн хаягдлын цэг тогтоож, зориулалтын хогийн сав байрлуулах				MNS 5344: 2011	
	Барилгын түр кемп тус бүрд хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх				Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	
	Хог хаягдлыг замбараагүй хаяж, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох			Барилгын ажлын туршид	Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам	
	Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих					
	Барилгын түр кемпүүдээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах					
Барилгын ажил дууссаны дараа хог хаягдлыг цуглуулж зайлуулах, талбайн цэвэрлэгээг бүрэн гүйцэд хийж хяналтын инженерт хүлээлгэн өгөх						

4. Гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчих байдлаар гадаргын болон газрын доорх усны бохирдол үүсгэх	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	500'000	Барилгын ажлын туршид	Усны тухайн хууль
	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх				MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах				
Барилгын болон ахуйн зориулалтаар багавтар хэмжээний ус ашиглах	Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус ашиглалтын гэрээ байгуулж ажиллах	Ундны усны эх үүсвэрт		Барилгын ажлын явцад улирал бүр	MNS0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
	Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах				
Шингэн хаягдал, 00-д хуримтлагдсан ялагдас зэрэг нь хөрсөнд нэвчиж газрын доорх усны найрлага, чанарт нөлөөлж болзошгүй.	Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх	Барилгын түр кемпүүдэд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	Барилгын ажлын явцад 7 хоног бүр	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
	Барилгын түр кемпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлорамин цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх				Эрүүл ахуйн тухай хууль
Их хэмжээний хур бороо орсны улмаас барилгын ажил явагдаж буй зам, талбай үерт автаж, машин техник эвдэрч гэмтэх, хүн осолдох	Онцгой байдлын төлөвлөгөө боловсруулж ажиллах, түүнд үерийн эрсдэлээс хамгаалах зохих арга хэмжээнүүдийг тусгаж өгөх	Барилгын ажил явагдах зам, талбай	Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид	Онцгой байдлын тухай хууль
	Барилгын түр кемпүүд, бүх инженерийн байгууламжууд нь үерээс хамгаалах байгууламжтай байх (үерээс хамгаалах далан, шуудуу зэрэг)				
5. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрс суларч доройтох, хөрсний элэгдэл үүсэж болзошгүй	Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах	Барилгын материал тээвэрлэх зам дагуу, барилгын талбай барилгын түр кемпүүд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан.	Тухайн цэг дээрх барилгын ажил дуусах үед	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль,
	Барилгын ажил дуусах үед хөрс суларч доройтон, хөрсний элэгдэл үүссэн газруудад нөхөн сэргээлт хийх				MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
10.2 талбайд хийгдэх газар шорооны ажлын улмаас нийт 30,564м3 хөрс хуулалт хийгдэж, хөрсөн бүрхэвчийн эвдрэл үүснэ.	Газар шорооны ажлын үед өнгөн хөрсний овоолгыг тусад нь үүсгэж стандартын дагуу хадгалах ба барилгын ажил дуусах үед нөхөн сэргээлтэд ашиглах	Газар шорооны ажил явагдах цэгүүд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан.	Газар шорооны ажил явагдах хугацаанд	MNS5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй.	Зам барилга, барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх	Зам барилга, барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль,
	Зам барилга, барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх				MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Бетон зуурмаг, асфальт материал тээвэрлэх, буулгах, хучилт хийх ажлуудыг нарийн чанд горимын дагуу тогтоосон талбайн хүрээнд гүйцэтгэж, хөрсөнд асгаралт үүсгэхээс сэргийлэх				
Хог хаягдал, кемпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдол зэргээс үүдэлтэй хөрсний бохирдол үүсэж болзошгүй.	Барилгын ба ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	Барилгын түр кемпүүд дэх хогийн цэг, 00-ийн цэг	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хууль
	Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох				Эрүүл ахуйн тухай хууль
	Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх				MNS 5344: 2011

2024 онд Толгойт дэд төвд хэрэгжүүлэх Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө, Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

	Барилгын түр кемпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлорамин цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх				Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
7. Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ					
Газар шорооны ажлын явцад газрын хөрсөнд нуугдмал байсан археологи, палеонтологийн санамсаргүй олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрч болзошгүй	Санамсаргүй олдвор илэрсэн цэгт барилгын үйл ажиллагааг нэн даруй зогсоох Санамсаргүй олдвор илэрсэн тухай дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх Археологийн хүрээлэнгийн мэргэжлийн баг ажиллуулж шаардлагатай судалгаа шинжилгээ хийлгэх, шаардлагатай бол авран хамгаалах малтлага хийлгэх Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах	Газар шорооны ажлын бүх цэгт	Барилгын ажлын төсөвт багтсан	Газар шорооны ажлын явцад, тухай бүрд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
8. Нийгэм, олон нийтэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Авто зам ба дулаан, цэвэр, бохир усны шугам хоолой тавих ажлуудаас тоосжилт үүсэж явган болон машинтай зорчигчийн үзэгдэх орчныг хязгаарлах	Газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд 1 м ² талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс газар шорооны ажлыг түр зогсоох Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Барилгын ажлын талбай	Энэхүү төлөвлөгөөний агаарын чанарын хэсэгт төсөвлөсөн төсвийн дагуу	хүлцэх хэмжээ	MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2010 Агаарын чанар - Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын
Барилгын материал тээвэрлэх, газар шорооны ажлуудаас дуу чимээ үүсэж ойр орчмын оршин суугчдын тав тухыг алдагдуулах	Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх Шаардлагатай тохиолдолд дуу чимээ тусгаарлах зөөврийн хана ашиглах Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх	Газар шорооны ажил явагдах цэгүүд, бүх тээврийн хэрэгсэл	Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид, өдөр бүр	MNS4585:2016 Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ
Зам барилга, газар шорооны ажлуудаас гэр хороолол дунд зорчих зам, орц, гарц хаагдаж боогдох	Зам барилгын ажлын улмаас тухайн замыг түр хаасан талаарх болон тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнд зориулан тогтоож өгсөн явах түр маршрутыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулах Барилгын материал хураах, хөрсний овоолго үүсгэх цэгийг сонгохдоо оршин суугчдын хөдөлгөөнд саад учруулах буюу орц гарцыг хаахгүй байхаар төлөвлөх	Барилгын ажлын бүх цэгт	Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид, өдөр бүр	MNS 5682:2006 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага
Зүсэх, бутлах, гагнах ажлуудын үед хэлтэрхий буюу гагнуурын оч үсэрч явган зорчигчийг гэмтээж болзошгүй	Зүсэх, гагнах ажлууд хийгдэх цэгүүдийг тойруулж хамгаалалтын хашлага татах, анхааруулах тэмдэг байршуулах	Шугам хоолойн угсралт явагдах цэгүүд	Барилгын ажлын төсөвт багтсан	Зүсэх, гагнах ажил явагдах үед	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
Барилгын материал тээвэрлэх үйл ажиллагааны үед зам тээврийн осол аваар гарах буюу ус зөөж буй хүүхдүүд, явган зорчигчдын аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй	Хүнд даацын машины жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын давтан сургалтад хамруулах, гэр хорооллын суурьшлын бүс дунд үүсэж болзошгүй эрсдэл, осол аваарын талаар тайлбарлан таниулах Гэр хороолол дунд тээврийн машины хурдыг хязгаарлах дүрэм мөрдүүлэх Тээврийн жолооч нарт худаг, хүүхдийн сургууль, цэцэрлэг, явган хүний гарц, уулзвар зэрэг осол аваар гарах эрсдэл бүхий цэгүүд дээр 5 секунд зогсоод хөдлөх дүрэм мөрдүүлэх	Тээврийн маршрут дагуу	500,000	Барилгын ажил эхлэхээс өмнө Барилгын ажлын туршид	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм
Зам талбай, шугам Хоолой тавих зорилгоор ухсан нүх, шуудуунд хүн унаж гэмтэх	Шугам хоолой байрлуулах зорилгоор ухсан нүх шуудууг хамгаалалтын тороор хашиж хүрээлэх, анхааруулах тэмдэг байрлуулах	Зам талбай, Шугам хоолойн угсралт явагдах цэгүүд	Барилгын ажлын төсөвт багтсан	Газар шорооны ажлын туршид	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
Кемпийн орчинд хог хаягдал, бохир усыг замбараагүй	Барилгын түр кемп бүрд дараах эрүүл ахуйн үндсэн шаардлагууд тавигдана. Үүнд:	Барилгын түр кемпүүд	Хог хаягдлын менежментийн	Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хууль

2024 онд Толгойт дэд төвд хэрэгжүүлэх Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө, Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

зайлуулснаас үүдэн орчны бохирдол, үнэр танар үүсгэх	1. Хатуу хог хаягдлын менежмент. Хатуу хог хаягдлыг түр хадгалах зориулалтын цэг бий болгож, хашлага хамгаалалт хийж, тэмдэг тэмдэглэгээ байршуулах, 2. СХД-ийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг 7 хоногт 2 удаа ачуулж байх 3. Шингэн хог хаягдлын менежмент. Кемпээс гарах бохир усыг битүү саванд түр хадгалж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх 4. Ажилчдын 00. Эрүүл ахуйн шаардлага хангасан 00-той байх, 00-н нүхэнд био-бэлдмэл ашиглаж халдваргүйжүүлэлт хийх, ойр орчмыг нь хлорамин шингэнээр тогтмол ариутгаж цэвэрлэх	Барилгын ажлын бүх цэгт	төлөвлөгөөнд тусгагдсан		Эрүүл ахуйн тухай хууль MNS 5344: 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
Кемпийн орчинд сахилга бат, хэв журмын зөрчил гаргаж оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	Барилгын ажилчдыг БОМТ, эрүүл ахуйн сургалтад хамруулж, зөрчлийн хуулийн холбогдох заалтуудыг сурталчлан таниулсан байх Кемпийн орчинд мөрдөх дотоод журамд сахилга батын асуудлыг нарийвчлан тусгаж өгөх ба үүнд согтууруулах ундаа хэрэглэх, ойр орчмын оршин суугчидтай асуудал зөрчил үүсгэх зэргийг хатуу хориглох	Барилгын бүх ажилчид	600'000	Жил бүрийн барилгын ажлын эхэнд	Зөрчлийн тухай хууль, MNS 4968 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
Замын ажилд ашиглагдах хүнд даацын машин механизмууд осол аваар гаргаж болзошгүй	Замын индүүдэгч, бетон зуурмаг, асфальт тээвэрлэгч, дэвсгэгч зэрэг том оврын машин тэрэгний ажлын үед хяналтын дохиурчныг зайлшгүй ажиллуулах шаардлагатай ба том оврын машин тэрэг ухрах, эргэх маневруудыг зөвхөн хяналтын дохиурчны дохиогоор хийж гүйцэтгэх	Зам барилгын ажлын талбайд	Барилгын ажлын төсөвт багтсан	Зам барилгын ажлын явцад	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм
Өндөр хэмтэй асфальт болон бетон зуурмаг алдагдаж хүний гар хөл түлэгдэж гэмтэж болзошгүй	Бетон зуурмаг, асфальт материал тээвэрлэх, буулгах, хүчилт хийх ажлуудыг нарийн чанд горимын дагуу тогтоосон талбайн хүрээнд гүйцэтгэж, санамсаргүй асгаралт үүсгэхээс сэргийлэх Зам барилгын ажлын талбарт ажиллаж буй ажилчид хамгаалалтын хувцас хэрэглэлтэй байх Зам барилгын ажил явагдаж буй цэгийг тойруулан хамгаалалтын хашлага татаж, анхааруулах тэмдэг байрлуулан явган зорчигчийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авах		600'000	Зам барилгын ажлын явцад	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
10. Ашиглалтын үеийн менежментийн арга хэмжээ					
Авто зам барих үйл ажиллагаанаас ахуйн хог хаягдал үүсэх	Авто зам ашиглалтын үе шатны захиргаа нь Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, харьяа дүүргийн Хот тохижуулах газартай хог хаягдлыг зайлуулах гэрээг байгуулж ажиллана. Хүүхдийн цэцэрлэг нь хог хаягдлыг цуглуулах зориулалтын цэгтэй байх бөгөөд дүүргийн ТҮГ-ний газартай гэрээ байгуулсны үндсэн дээр цугларсан хог хаягдлыг 7 хоногт 2 удаа ачуулна.		Улсын төсөвт байгууллагын үйл ажиллагааны зардал, төсвөөс санхүүжнэ.	7 хоногт 2 удаа	Хог хаягдлын тухай хууль
Авто зам доогуур тавьсан ус зайлуулах хоолой хог хаягдал ба хагшаасаар дүүрч бөглөрөх	Толгойт дэд төв дотор тавигдах 5.9 км авто замын засвар арчилгааны ажлыг Нийслэлийн Авто Замын Газар хариуцан ажиллах бөгөөд төлөвлөгөөт урсгал засвар, зам арчилгааны ажлуудыг тогтмол хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ. Ус зайлуулах хоолойг цэвэрлэх ажлыг хур борооны улирлын өмнө ба дараа буюу хавар, намрын улирлуудад жил тутам тогтмол хуваарийн дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай юм.	Зам доогуур тавих ус зайлуулах хоолой	Нийслэлийн Авто Замын Газрын үйл ажиллагааны зардал, төсвөөс санхүүжнэ.	Жил бүр тогтмол хуваарийн дагуу	Авто замын тухай хууль
TRDH11A- Толгойт дэд төвийн авто зам болон дагалдах ИШС (3-р хэсэг)			837,311		
TRDH11B- Толгойт дэд төвийн авто зам болон дагалдах ИШС (4-р хэсэг)			837,311		
TRDH11C Толгойт дэд төвийн насос станц болон усан шугам сүлжээ			837,311		
TRDH11D Толгойт дэд төвийн авто зам			837,311		
TRDH14A Толгойт дэд төвийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (1-р хэсэг)			837,311		
TRDH14B Толгойт дэд төвийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (2-р хэсэг)			837,311		
Нийт төсөв:			5,023,870		

5.2. Мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт (ТЭС)

ТЭС-А	Толгойт дэд төвийн мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт	Холбооны шугам: урт 7.14 км, диаметр: 110мм, байр төв 925м ² болон 272м ² - 2ш Нөлөөлөлд өртөх талбай: 4,767м²
ТЭС-В	Толгойт дэд төвийн цахилгааны хаалттай дэд өртөө ба 10кВ цахилгаан дамжуулах кабель шугам	• 10/0.4кВ хүчин чадалтай хаалттай дэд станц (ХТП)-1 РП, кабель шугам 47500м Нөлөөлөлд өртөх талбай: 24,850 м²
ТЭС-С	Толгойт дэд төвийн цахилгааны хуваарилах байгууламжууд ба 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам	• Цахилгааны кабель шугам: урт= 42500 м, удирдлагын байр 140м ² Нөлөөлөлд өртөх талбай: 21,390м²

Хүснэгт 29. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (ТЭС)

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Шаардагдах зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Газар шорооны ажилд 0.8 га талбайн газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүсэх	Цахилгааны кабель, шилэн кабель, холбооны шугам тавих, ХТП, холбооны төвийн барилга барих ажилд өртөж эвдэрсэн 0.35 га талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн дүүргэлт, тэгшилгээний ажлууд хийж, анхны төрх байдалд нь нийцүүлэн хэлбэршүүлэх	Газар шорооны ажил явагдах бүх цэгт	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Тухайн цэг дээрх барилгын ажил дуусах үед	Нөхөн сэргээлтийн стандарт MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008
Газар шорооны ажлаас 9350 м ³ хаягдал шороон материал үүсэх	9350м ³ хэмжээтэй шороон материалыг шуудууны нөхөн дүүргэлтэд ашиглах ба үлдсэн 2,028 м ³ хэмжээтэй хаягдал шороон материалыг Цагаан давааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг СХД-ийн хот тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө. Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.		Газар шорооны ажил явагдах хугацаанд, 7 хоног бүр	Газар шорооны ажил явагдах хугацаанд, 7 хоног бүр	Барилгын хог хаягдлыг цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам MNS BS 5906:2015 Барилгын хог хаягдлын менежмент, ашиглалтын дүрэм
Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орох	Газар шорооны ажлаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрласан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх	Газар шорооны ажил явагдах бүх цэгт	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Газар шорооны ажил явагдах хугацаанд	MNS5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Газар шорооны ажил, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас тоосжилт үүсэж агаар орчныг бохирдуулах	Хуурай өдрүүдэд газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд м2 талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох Хүчтэй салхи шуургатай үед хөрсний овоолгоос тоосжилт үүсэхээс сэргийлж усалгаа хийх Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Газар шорооны ажил явагдах бүх цэгт	3'531'540 1200000	Барилгын ажлын туршид,	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага
Барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал,	Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл,	Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид, 7 хоног бүр	MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ

2024 онд Толгойт дэд төвд хэрэгжүүлэх Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө, Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах	Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх	машин механизмууд			MNS4990:2010 Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ
	Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах			ОХШХ-т тусган оруулсан	
3. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Кабель шугам тавих нүх шуудуу ухах, булах ажил, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүсэх	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийн үзлэг, оношилгоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид,	MNS4585:2016 Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ, MNS4995:2015 Ажлын орчинд дуу чимээний давтамж болон хэлбэлзэл
	Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх	Барилгын ажлын талбай	ОХШХ-т тусган оруулсан		
	Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих				
Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж, зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	СХД-ийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж, түүнд хаягдал шороон материал, ахуйн ба барилгын хог хаягдлыг зайлуулах цэг ба тээвэрлэх автомашины улсын дугаарыг тодорхой зааж өгөх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	Барилгын ажил эхлэх үед, 2024 оны 2-р улиралд	Хог хаягдлын тухай хууль, MNS 5344: 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага, Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам
	Барилгын ажил явагдаж буй газруудад хогийн хаягдлын цэг тогтоож, зориулалтын хогийн сав байрлуулах				
	Барилгын түр кемп тус бүрд хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх				
	Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох				
	Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих				
	Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах				
	Барилгын ажил дууссаны дараа хог хаягдлыг цуглуулж зайлуулах, талбайн цэвэрлэгээг бүрэн гүйцэд хийж хяналтын инженерт хүлээлгэн өгөх				
4. Гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчих байдлаар гадаргын болон газрын доорх усны бохирдол үүсгэх	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид,	Усны тухайн хууль, MNS 6148 :2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх				
	Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах				
